

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЙЛАН 2020



ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЙЛАН 2020



Тус тайланг Нээлттэй Нийгэм Форумын
дэмжлэгтэйгээр хэвлэв.



Бэлтгэсэн:

Б.Пүрэвсүрэн

Б.Онон

Ц.Лхагвасүрэн

Л.Галбаатар

М.Оюунхорол

Хянан тохиолдуулсан:

Т.Аюушжав

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт	6
Өмнөтгөл	7
НЭГ. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ	10
1.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа	10
1.2. Хэвлэлийн эрх чөлөө ба сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа	12
1.3. Мэдээллийн эрх чөлөө ба хязгаарлалт	17
1.4. Сонгууль ба хэвлэл мэдээлэл	22
1.5. Нэр төр гутаахтай холбоотой зохицуулалт	24
1.6. Агуулгын хязгаарлалт	27
1.7. Бусад зохицуулалт	31
Хаалтын гэрээ	33
Интернэт буюу цахим орчин	35
Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт	36
ХОЁР. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ	38
ГУРАВ. СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭСРЭГ ИРГЭНИЙ БА ЭРҮҮГИЙН ХЭРЭГ	46
Хавсралт 1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэх талаар НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлөөс Монгол улсад өгсөн зөвлөмж (UPR)	49
Хавсралт 2: КОВИД-19 цар тахлын үе дэх иргэний болон улс төрийн эрхийн зөрчлийн мониторингийн тайлан	51

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГИТ	Глоб Интернэшнл төв
УИХ	Улсын Их Хурал
МИТБМАЭ	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
МУИХС	Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль
ХЭХЭЗБ	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль
ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний Комисс
ИБУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
УОК	Улсын онцгой комисс
ХЭФ	Хүний эрхийн Форум

График мэдээллийн жагсаалт

График 1. Иргэний болон улс төрийн эрхийн зөрчлийн эзлэх хувь

Хүснэгтэлсэн мэдээллийн жагсаалт

Хүснэгт 1 1999-2020 оны хэргийн харьцуулсан үзүүлэлт

ӨМНӨТГӨЛ

Жил бүрийн тавдугаар сарын 3-ны өдөр дэлхий даяар тэмдэглэдэг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр (ДХЭЧӨ)-ийг тохиолдуулан бэлтгэдэг хэвлэлийн эрх чөлөөний ээлжит тайлангаа та бүхэнд толилуулж байна.

Энэ жилийн ДХЭЧӨ нь 1991 оны тавдугаар сарын 3-ны өдөр Намиби улсын нийслэл Виндхук хотноо болсон ЮНЕСКО-ийн Бага хурлаас баталсан Виндхукийн Тунхаглалын 30 жилийн ойтой түүхэн холбоотой билээ. 1993 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлын Зөвлөмжийн дагуу уг Тунхаглал батлагдсан энэ өдрийг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр болгон жил бүр тэмдэглэх шийдвэр гарсан билээ. Түүнчлэн, Монгол Улс Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрч, НҮБ-ын гишүүн болсны 60 жилийн ойтой давхцаж байна.

2021 оны ДХЭЧӨ-ийг ЮНЕСКО-оос “Мэдээлэл нийтийн сайн сайхны төлөө байх нь” сэдвийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэхээр үзэл баримтлалдаа дурдаж, дэлхийн хэмжээнд болон дотооддоо нийтээр хэлэлцвэл зохих гурван дэд сэдвийг:

“1. Мэдээний хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн эдийн засгийн оршин тогтнох баталгааг хангах арга зам;

2. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийн ил тод байдлыг хангах механизм;

3. Хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсролын чанарыг дээшлүүлэх нь” хэмээн тодорхойлжээ. Энэ жилийн хүчин чармайлт нь олон нийтийн эрх ашгийн төлөө нотлогдсон мэдээ бэлтгэхэд сэтгүүл зүйн онцгой үүрэг нь мэдээллийг нийтийн сайн сайхны төлөө байлгах боломж олгодог өргөн хүрээтэй экосистемээс хэрхэн хамаарч буйд анхаарал төвлөрүүлэх зорилготой болохыг ЮНЕСКО онцлон тэмдэглэж байна.

Хүн төрөлхтөн цар тахлаас үүдэлтэй томоохон сорилттой тулгарсан хэвээр байна. Дэлхийн улс орнууд КОВИД-19 цар тахлын бэрхшээлээ даван туулахаар хамтын хүчин чармайлтаа зарлан мэдэгдэж, өөр өөрийн хариу арга хэмжээг авч байгаа энэ цаг үед иргэдийн мэдээлэлтэй байх, сэтгүүлчдийн мэргэжлийн эрх, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний байдал хурцадмал байна. Энэ цаг үед иргэд найдвартай, нягт нямбай, үнэн бодит мэдээлэлтэй байх нь юу юунаас илүү чухал байна. Ийм ч учраас ЮНЕСКО-оос “Дисинфодемик буюу хуурамч мэдээллийн цар тахал” сэдэвт “КОВИД-19-тэй холбоотой хуурамч мэдээллийг ухаж ойлгох нь”, “КОВИД-19-тэй холбоотой хуурамч мэдээллийг нэгтгэн авч үзэх нь” хэмээх цуврал бодлогын баримт бичиг боловсруулсан юм. DISINFODEMIC (Disinformation pandemic) буюу

“хуурамч мэдээллийн цар тахал” гэсэн нэр томъёо сонгосон учир нь “КОВИД-19-тэй холбоотой хуурамч мэдээлэл анагаахын шинжлэх ухааны талаар төөрөгдөл үүсгэж, манай гарагийн хүн бүрт төдийгүй бүхэл бүтэн нийгэмд тэр даруй нөлөөлж байна. Энэ нь бусад сэдвээрх хуурамч мэдээллээс илүү хүний аминд хүрэхээр хор хөнөөлтэй байна. Өнөөдөр КОВИД-19 цар тахал үргэлжилсээр байгаа үед энэ нь үхэл, амьдралын асуудал болж байна” гэжээ. “Хуурамч мэдээлэл нь баримт, өгөгдөл, тайлбарын сөргөлдөөнийг хурцатгаж, нөлөө бүхий үзэл бодол, эсвэл туршлага, баримтын хоорондын шугамыг бүдгэрүүлж, мөн үнэ цэн бүхий эх сурвалжид үл итгэх байдлыг өөгшүүлдэг” хэмээн уг Бодлогын баримт бичигт тэмдэглэжээ. Бодлогын баримт бичгийн нэгдүгээр хэсгийн орчуулгыг манай байгууллагын цахим хуудаснаас уншиж болно.

Иргэдийг хуурамч мэдээллээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэхэд мэргэжлийн сэтгүүл зүй чухал үүрэгтэй. Харин хуулийн хатуу хязгаарлалт, мэргэжлийн эрхээ зохих ёсоор биелүүлэхэд нь саад тотгор учруулж буй нь харамсалтай. Хүний эрхийн Үндэсний Комиссоос УИХ-д илгээсэн “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл”-д “Гамшгийн үед олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх хууль зүйн арга хэмжээ авсан нь хүний эрхийн зарчимд нийцнэ. Харин эдгээр хууль тогтоомжийн “илт худал мэдээлэл”, “худал мэдээлэл тараах” гэх хууль зүйн ойлголт нэг мөр болоогүй нь эрх бүхий этгээдээс хуулийн заалтыг дур зоргоор тайлбарлах, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах эрсдэл үүсгэж байгаа талаар мэргэжлийн байгууллагуудаас тавьж байгаа шүүмжлэл үндэслэлтэй юм” гэжээ.

Цар тахалтай холбоотой хийгдсэн эрх зүйн өөрчлөлтүүдийг практик дээр иргэдийн эсрэг хэтрүүлэн ашиглаж байгаа нь харамсалтай. Манай байгууллагын 2020 оны 11 дүгээр сарын 25-наас 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл гурван сарын хугацаанд иргэний болон улс төрийн эрхийн зөрчилд хийсэн мониторингийн дүнгээр нийт 80 шахуу зөрчил бүртгэгджээ. Мөн Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс өнгөрсөн оны сүүлээр сэтгүүл зүйн 300 бүтээлч ажилтны дунд хийсэн судалгаагаар тэдний талаас дээш хувь нь “бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнээс хойш манай улсад хэвлэлийн эрх чөлөө хумигдсан” гэж үзсэн байна. Судалгаанд хамрагдагчдын гуравны хоёр нь тэдний түгээсэн бүх ба ихэнх мэдээлэлд албаны эх сурвалж зонхилсон гэжээ. Эх сурвалжийн тэнцвэрт байдал хангахад тулгарсан бэхшээлийн хувьд “сэтгүүлчид өөрийн цензурт автсан” гэдгээ онцолсон байна.

2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн 36 дахь чуулганаар Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг гурав дахь удаагаа дүгнэн хэлэлцэв. Тус чуулганыг 2020 оны 5 дугаар сарын 4-ноос

15-ны өдөр товлосон байсан хэдий ч дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахлын улмаас ийнхүү хойшилж, цахимаар явагдсан юм. Харамсалтай нь, үзэл бодлоо, илэрхийлэх эрх чөлөөний талаар НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн өмнөх хуралдаанаас өгсөн найман зөвлөмж хэрэгжээгүй бөгөөд энэ удаа Хүний Эрхийн Зөвлөлөөс Монгол улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүрэн утгаар нь хэрэгжүүлэхийн тулд нэр төр гутаахтай холбоотой хэргийг Эрүүгийн хуулиас хасах, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг үйлдсэн халдлагыг хараат бусаар мөрдөн шалгах нөхцөлийг баталгаажуулах, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангах, хувь хүний нууцаа хамгаалуулах эрхийг хөхиүлэн дэмжиж, өгөгдөл хамгаалах үр дүнтэй хууль тогтоомж батлах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон интернэтийн хэрэглээнд тогтоосон хязгаарлалтыг цуцлах талаар шаардлагатай хүчин чармайлт гаргах зэрэг зөвлөмж нэмж өгсөнийг УИХ болон Засгийн газар хэрэгжүүлнэ хэмээн найдаж байна.

2020 онд УИХ-ын, мөн орон нутгийн сонгууль явагдсан. Өнгөрсөн жил УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн сурталчилгаа хууль, эрх зүйн шинэлэг орчинд явагдсанаараа онцлог байв. Учир нь, 2015 онд нэгтгээд байсан сонгуулийн хуулийг 2020 онд өөрчилж, Ерөнхийлөгч, УИХ, орон нутгийн сонгуулийг тус тусын хуулиар явуулахаар болсон. Гэсэн хэдий ч эдгээр хуулиудад сэтгүүл зүйн үйл ажиллагаанд халтай зүйл заалтууд хэвээр үлдсэн бөгөөд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагууд хуулийн хатуу хязгаарлалт бүхий нөхцөл дор сонгуулийн мэдээ сурвалжилга бэлтгэв.

Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар, 2019 оны эцсийн байдлаар (цар тахлын нөхцөл байдлаас үүдэн 2020 оны судалгаа хараахан эцэслэгдээгүй байв) манай улсад 500 орчим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 4750 хүн ажиллаж байна. Тэдний тал орчим хувь нь бүтээлч ажилтан буюу сэтгүүлч, сурвалжлагч байна.

“Хил хязгааргүй сурвалжлагчид” (RSF) олон улсын байгууллагын Хэвлэл эрх чөлөөний 2021 оны индексээр Монгол Улс дэлхийн 180 орноос 68 дугаарт жагсаж, өнгөрсөн жилийнхээс таван байр урагшилсан хэдий ч хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдал “асуудал”-тай орны тоонд багтсан хэвээр байна.

Х.Наранжаргал

Глоб Интернэшнл төвийн Удирдах зөвлөлийн дарга

НЭГ

ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ
ЗҮЙН ХҮРЭЭ1.1. ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ
БАТАЛГАА***Үндсэн хууль ба олон улсын эрх зүйн хэм хэмжээ***

Монгол Улсын Үндсэн хуулийн Хүний эрх, эрх чөлөө бүлгийн 16 дугаар зүйлийн 16 дахь хэсэгт Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг баталгаажуулсан. 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан. Мөн 16.17 дугаар зүйлд “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” хэмээн заасан байдаг. Үндсэн хуульд мэдээлэл “түгээх” эрхийн тухай үгчлэн оруулаагүй хэдий ч олон улсын гэрээ конвенцийн дагуу “хил хязгаар үл харгалзан”¹ мэдээлэл “хайх, хүлээн авах болон түгээх” эрх баталгаажсан гэж үздэг.

Монгол Улс 1961 онд НҮБ-ын гишүүн улс болсон бөгөөд түүний хувиар Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИБУТЭОУП)-ыг соёрхон баталж, 2012 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын оролцогч улс болсон. Тиймээс олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу иргэдийнхээ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах үүрэг хүлээнэ. Энэ үүргийг Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан. Эдгээр олон улсын гэрээ конвенц 2004 оны “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаарт монгол хэлнээ албан ёсоор хэвлэгдсэн.

¹ ИБУТЭОУП-ын 19-р зүйл (2)

Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлүүдэд “Хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр, эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана”. ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариуцлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах шаардлагаас үүдэн гарсан байх ёстой; а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах” гэж хязгаарлалтыг нарийвчлан тодорхойлжээ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарим хязгаарлалтыг Үндсэн хуулийн үзэл баримтлал болоод олон улсын гэрээ конвенцыг удирдлага болгож, гурван талт шалгуур /Three part test/-т бүрэн нийцсэн тохиолдолд хүлээн зөвшөөрөх ёстой. Үүнд:

Нэгдүгээрт. Гагцхүү хуулиар тогтоох буюу хууль ёсны зорилготой байх.

Хоёрдугаарт. Хэм хэмжээндээ байх, өөрөөр хэлбэл, олон улсын хуулиар хүлээн зөвшөөрсөн хязгаарлалтын зарчимд нийцэх (ИБУТЭОУП-ын 19.3).

Гуравдугаарт. Зайлшгүй буюу гарцаагүй байх.

Үүнээс илүү хязгаарлалт хийхийг ардчилсан нийгэмд үл хүлээн зөвшөөрөх хэдий ч хэтийдсэн хязгаарлалтыг хууль тогтоомжид тусгах буюу практикт хэрэглэсээр байна. 2011 оны 7 дугаар сарын 11-29-ний өдрүүдэд Женев хотноо болсон НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны 102 дугаар чуулганаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа болсон ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 34 тоот Ерөнхий тайлбарыг (албан бус орчуулгыг манай байгууллагаас хийсэн²) монгол хэлнээ албан ёсоор орчуулж, практикт хэрэглэж хэвших, олон нийтэд болон холбогдох албан тушаалтнуудад таниулан сурталчлах шаардлагатай байна.

2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт орж, зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй” гэж зааснаар тодорхой асуудлаар иргэдийн мэдээлэл эрж хайх, хүлээн авах, түгээх эрхийг баталгаажуулсан юм.

² https://www.gic.mn/public/docs/publications/General_comment_No34_ICCPR_Art19_mon.pdf

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.17 дахь хэсэгт “Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувьхүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” хэмээн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тавьж болох зорилго, үндэслэлийг заасан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.4.4 хэсэгт “Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй” гэж заасан байдаг. Итгэл үнэмшилтэй байвч түүнийгээ илэрхийлэх арга хэрэгсэлгүй бол энэ эрх хэрэгжих боломжгүй юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсэн, хэвлэн нийтэлсний төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар хуульчилсан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулахад нэг алхам урагшилсан. Мөн Эрүүгийн хуулийн 14.3 дугаар зүйлд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдахыг гэмт хэрэгт тооцохоор болсон. Тухайлбал, “Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол...” гээд хүлээх хариуцлагад торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заасан.

Тэгвэл Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойшх хугацаанд уг гэмт хэргийн дагуу 2018, 2019 онуудад тус бүр нэг хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас хэрэгт бүртгэлийн хэргийг хаасан нэг, шүүхэд шилжүүлсэн нэг хэрэг тус тус байгаа тухай Монгол Улсын Ерөнхий Прокурорын газраас Глоб Интернэшнл төв (ГИТ)-д ирүүлсэн³ албан бичигтээ дурдсан байна. Үүнээс харахад, иргэний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг Эрүүгийн хуулиар хамгаалж, гэмт хэрэгт тооцох болсон боловч иргэд төдийгүй сэтгүүлчид хүртэл эдгээр эрх зөрчигдсөн асуудлаар цагдаагийн байгууллагад тэр бүр гомдол гаргаж, асуудлаа шийдвэрлүүлдэггүй нь харагдаж байна.

1.2. ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА СЭТГҮҮЛ ЗҮЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2, 3 ба 4 дүгээр зүйлд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн

³ 2021.04.19-ний өдрийн 1/2298 тоот албан бичигт

хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргах болон төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байх, төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг тус тус хориглосон нь хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан суурь зохицуулалт болдог. Улсын Дээд Шүүхийн тайлбарт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл” гэдгийг “Зар сурталчилгааны тухай” хуулийн 3 дугаар бүлэгт 3.1.5 дахь хэсэгт “Мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерийн сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгсэл” гэсэн утгаар ойлгоно хэмээн тогтоосон.

УИХ-аас 2005 оны нэгдүгээр сарын 27-ны өдөр “Олон нийтийн радио, телевизийн тухай” хууль баталснаар үндэсний хэмжээнд олон нийтэд үйлчлэх, түүний хяналт санхүүжилтэд байх статус бүхий телевиз, радиогийн эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Түүнээс хойш хэвлэл мэдээллийн салбарт шаардлагатай байгаа сэтгүүлчийн нууц эх сурвалж болон мэдээлэгчийг хамгаалах, салбар дахь шударга өрсөлдөөн, өмчлөлийн ил тод байдлыг хангах тухай эрх зүйн зохицуулалт хийгдээгүй. Харин УИХ-аас 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийг баталсан. Монгол Ардын Нам 2020 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөртөө 4.4.2-т “Хэвлэлийн эрх чөлөөг хуулиар хамгаалж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг хязгаарласан аливаа бодлого хэрэгжүүлэхгүй” тухай заажээ. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэд хэдэн төсөл боловсруулагдаж байсан ч, УИХ-аар хэлэлцүүлж батлуулаагүй байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, албан ёсны цахим хуудастаа 2020 оны 12 дугаар сарын 8-ний өдөр байршуулсан. Үүнд: Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Худал мэдээлэл тараах гэмт хэрэгт хүндрүүлэх бүрэлдэхүүн оруулах санал боловсруулсан байв. Энэхүү төслөөр худал мэдээлэл тараах гэмт хэрэгт оногдуулах ял, хариуцлагыг чангатгаж, өмнө 450-2700 нэгжтэй тэнцэх /450.000 - 2.700.000 төгрөг/ мөнгөн торгууль оногдуулдаг байсныг 5400 нэгжтэй тэнцэх /5.400.000 төгрөг/ хэмжээний торгууль оногдуулах болон нэг жил хүртэл хорих ялаар шийтгүүлэх зохицуулалт агуулсан байв. Цаашилбал, энэ гэмт хэргийг "зохион байгуулалттай бүлэглэл" үйлдсэн бол /3 болон түүнээс дээш хүн оролцсон/ 27 сая хүртэл төгрөгөөр торгох, эсвэл таван жил хүртэл хугацаагаар хорих, хуулийн этгээд оролцсон бол 80 сая хүртэл төгрөгийн торгууль оногдуулахаар хуулийн төсөлд тусгасан байв..

Хэвлэл мэдээллийн байгууллагууд, мэргэжлийн эвлэл, холбоод, иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс уг хуулийн төслийг буруушааж, хамтарсан мэдэгдэл гаргах, ХЗДХ-ийн сайдад захидал хүргүүлэх, уулзалт

зохион байгуулах зэргээр эсэргүүцлээ илэрхийлсэн. Үүний үр дүнд ХЗДХЯ-наас уг хуулийн төслийг УИХ-ын чуулганд өргөн барихаас татсан бөгөөд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулсны дараа холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаа мэдэгдсэн.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 7.1.2 дахь хэсэгт “хууль тогтоомж, захиргааны байгууллагын шийдвэрийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хүний эрхийн үндсэн зарчимд нийцэж байгаа эсэх талаар санал гаргах” эрхтэй байхаар хуульчилсан. Энэ дагуу 2021 оны нэгдүгээр сарын 13-ны өдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн А/О1 тушаалаар⁴ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр УИХ-аас дараах хэд хэдэн бодлогын баримт бичиг боловсруулан баталсан. Тухайлбал, УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.5-д “Мэдээллийн эрх чөлөө, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах талаар” авах арга хэмжээг тусгасан бөгөөд тус хөтөлбөрийн 2.2.5.4-т “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбогдох бүх хууль тогтоомжид судалгаа хийж, зөрчилтэй зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно”; 2.2.5.6-д “Мэдээллийн эх сурвалжаа нууцлан хамгаалах сэтгүүлчийн эрх, үүргийг хуулиар баталгаажуулж, иргэд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний нэр, нэр төр, алдар хүндийн халдашгүй байх эрхийг зөрчихөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь бүрэн сэргээх эрх зүйн механизмыг тодотгон сайжруулна” гэж тус тус заасан.⁵

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.5.9-д “Хэвлэлийн эрх чөлөөг бүх талаар хангаж, ёс зүйтэй, мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлнэ”⁶ гэж заасан бол Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.4-т “Хэвлэл мэдээллийн салбарыг үнэн бодит мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх чиглэлээр хөгжүүлнэ”⁷ гэсэн байна.

⁴ <https://nhrcm.gov.mn/%D0%BC%D1%8D%D0%B4%D1%8D%D1%8D/freedom/>

⁵ УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”

⁶ УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”

⁷ ЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”

Үүнд: “Хэвлэл мэдээллийн салбарын үнэн бодит мэдээлэл түгээх, соён гэгээрүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх”-ээр заасан. Тус хөтөлбөрийн 4.4.11-т “Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулна”. Мөн “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах тухай хуулийн төслийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”-ээр заасан.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх бодлогыг төр, иргэн, хэвлэл мэдээллийн салбар хамтран хэрэгжүүлнэ” (3.3.3.2); “хэвлэл мэдээллийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлж, хариуцлагатай, мэргэшсэн сэтгүүл зүй, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, нийгмийн тогтвортой байдлыг хангана” (3.3.4.3) гэж заасан байдаг.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх Ажлын хэсгээс 2021 оны гуравдугаар сард 80 гаруй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны дунд хийсэн судалгааны дүнгээс харахад, манай улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөөний нөхцөл байдал “дунд” түвшинд, харин сэтгүүлчдийн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн талаарх мэдлэг ойлголт “хангалтгүй” гэсэн байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 64.6 хувь нь “Монголын хэвлэл мэдээллийн эрх чөлөө “дунд” түвшинд байна гэж үнэлсэн байна. Судалгаанд оролцогчдын 58 хувийн “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль”-ийн тухай мэдлэг, ойлголт нь “сайн, гэхдээ хангалттай биш” бол 23.5 хувь нь “бага зэрэг мэднэ”, харин 13.6 хувь “огт мэдэхгүй” гэжээ. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж судалгаанд оролцогчдын 83.8 хувь нь үзсэн байна. Энэхүү хууль тогтоомжийг сайжруулснаар “иргэний мэдээлэл авах эрх хангагдана” гэж 48.8 хувь, “чөлөөт хэвлэл хөгжих орчин, нөхцөл сайжирна” гэж 46.3 хувь, “сэтгүүлчийн ёс зүй сайжирна” гэж 42.7 хувь үзсэн бол 41.5 хувь нь “сэтгүүлчийн мэргэжлийн эрхийг хангана” гэсэн хүлээлттэй байгаагаа онцолжээ. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд эх сурвалжаа нууцлах эрхийг хангах, сэтгүүлчийн бие даасан, аюулгүй байдлыг хангах, хууль хүчний байгууллагад дуудагдаж, айлган сүрдүүлдэгт өртөх явдлыг халах, төрийн байгууллагын нээлттэй байдлыг бий болгох, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг заах зэрэг асуудлыг тусгах нь чухал гэж судалгаанд оролцогчид үзжээ.

Олон улсын хэмжээнд Монгол дахь хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдал тийм сайн биш гэсэн үнэлгээтэй байна. “Хил хязгааргүй сурвалжлагчид” (RSF) олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг хэвлэлийн

эрх чөлөөний 2021 оны индексээр Монгол Улс 180 орноос 28.97 оноотойгоор 68 дугаар байрт⁸ жагсаж байна. Энэ нь өмнөх оныхоос 5 байр урагшилсан үзүүлэлт бөгөөд хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдал “асуудалтай” орны тоонд багтсан хэвээр байна. RSF-ын дүгнэж байгаагаар, өнгөрсөн жилийн хувьд Монголын сэтгүүлчид гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх эрх мэдлийн өмнө хараат бус байдлаа хадгалж чадсанаар цар тахалтай холбоотой мэдээллийг хязгаарлах явдлыг амжилттай эсэргүүцсэн хэмээн дүгнэсэн.⁹ “Асуудалтай” орнуудын тоонд манайхаас гадна энэ жил 58 орон багтсан байна. Хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдал “хангалттай сайн” гэдэг ангилалд багтахын тулд манай улсын хувьд энэ жилийн үзүүлэлтээ ахин 20 байраар урагшлуулж, 48 буюу түүнээс дээш байранд жагсах шаардлагатай. Манай улсын үнэлгээ 2005 ба 2015 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан бөгөөд 54 дүгээрт жагсаж байв. 2015 оны хувьд, өмнөх жилийнхээс 34 байраар огцом урагшилсан нь 2014 онд зөрчлийн тоо бага байснаас гадна мэдээллийн ил тод байдлын хуулийн үр нөлөө гарч эхэлсэн хэмээн олон улсын шинжээчид дүгнэдэг.¹⁰

СЭТГҮҮЛЧИЙН НУУЦ ЭХ СУРВАЛЖ

Монгол Улсад сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалсан хууль тогтоомж одоо хүртэл батлагдаагүй. Харин Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн хороодын 2015 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан ёс зүйн зарчмын 8 дахь хэсэгт “Мэдээллийн нууц эх сурвалжаа чандлан хамгаална” гэж зааснаар сэтгүүлчид нууц эх сурвалжаа хамгаалах ёс зүйн үүрэг хүлээдэг.

Үүнээс гадна, 2016 онд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тоот тогтоолоор баталсан нь дэвшилттэй зүйл болсон. Учир нь, тус хөтөлбөрийн 4.1.8 дахь хэсэгт хэвлэл мэдээллийн байгууллагын хараат бус байдал, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой ажлууд хийхээр тусгаад байна. Тухайлбал:

- хэвлэл мэдээллийн байгууллагын мэдээлэл олж авах, түгээх эрхийг баталгаажуулах /4.1.8.1./;

⁸ <https://rsf.org/en/ranking>

⁹ <https://rsf.org/en/rsf-2021-index-censorship-and-disinformation-virus-hits-asia-pacific>

¹⁰ <https://www.dw.com/en/reporters-without-borders-new-threats-against-freedom-of-the-press/a-18250740>

<https://reliefweb.int/report/world/world-press-freedom-index-2015-decline-all-fronts>

- эрэн сурвалжлах замаар авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлсэн сэтгүүлчийг аливаа дарамт, шахалтаас хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, сэтгүүлчийг мэргэжлийн үйл ажиллагааных нь улмаас эрүүгийн хариуцлагад татах явдлыг өөрчилж, аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бий болгох /4.1.8.2./;
- хэвлэл мэдээллийн байгууллагын бие даасан, хараат бус байдал, хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлэх /4.1.8.3./ гэж тус тус заасан.

Эдгээрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө батлагдаж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор сэтгүүлчийн нууц эх сурвалж, шүгэлдэгчийг хамгаалсан эрх зүйн орчинг бүрдүүлэхээр Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Одоогоор энэхүү хуулийн төсөл УИХ-д өргөн баригдаагүй хэвээр байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг УИХ-аас 2021 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр баталсан бөгөөд уг хууль 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлснээр эх сурвалжийг хамгаалах асуудалд ахиц гарах төлөвтэй байна.

1.3. МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БА ХЯЗГААРЛАЛТ

УИХ-аас 2005 онд баталсан Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д “Олон нийтийн радио, телевизийн ажилтан төр, байгууллага болон хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээллийг олж авах, нийтийн хүртээл болгох эрхтэй” гэж МҮОНРТ-ийн ажилтнуудын эрхийг баталгаажуулсан. 2020 оны 12 дугаар сард Нээлттэй Нийгэм Форум болон ГИТ хамтран зохион байгуулсан олон талын оролцоот цахим хэлэлцүүлгийн үр дүнд “Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өгөх санал, шүүмж”¹¹-ийг бэлтгэн гаргасан. Уг хэлэлцүүлэгт оролцогчдын зүгээс, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх; Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасны дагуу хуулийн хэрэгжилтийг үнэлэх сонсгол зохион байгуулах; хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасан зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг байгуулах; МҮОНРТ-ийн ажиллагсдын нийгмийн асуудлыг хуульчлан зохицуулах; хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан нэгжийг байгуулах; олон нийтийн өргөн нэвтрүүлгийн

¹¹ https://www.forum.mn/res_mat/2021/OSF_Law%20review_31.pdf

талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах; хуульд редакцын хараат бус байдлыг хангах зохицуулалтыг нэмж тусгах талаарх саналуудыг гаргасан.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай (МИТБМАЭ) хууль 2011 онд батлагдсанаар мэдээлэл олж авах эрхээ эдлэх боломж, нөхцөл иргэд, хуулийн этгээдэд төдийгүй хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдэд бүрдсэн юм. Гэвч МИТБМАЭ-ийн тухай хуулийн хэрэгжилт төдийлэн хангалтгүй байгаа талаар өнгөрсөн хугацаанд хийсэн дараах судалгаанууд харуулдаг. Тухайлбал, IRIM судалгааны хүрээлэнгийн 2012 онд хийсэн “Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын тухай” судалгааны тайлан, ГИТ-өөс 2013 онд хийсэн “Иргэдийн мэдээлэл авах эрхийг нэмэгдүүлж, Монголд ил тод шударга байдлыг хөхиүлэн дэмжих нь” суурь судалгаа, ГИТ ба Зориг сангийн 2014 онд хамтран хийсэн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн 23, 24 дүгээр зүйлийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан”, ГИТ-өөс 2019 онд хийсэн “Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээний тайлан” судалгаануудаас дэлгэрэнгүй мэдээлэл авч болно. Тус хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн нэг жишээ бол иргэн, хуулийн этгээдийн зүгээс төрийн байгууллагын холбогдох албан тушаалтны нэр дээр хаяглаж мэдээлэл хүсэхэд, алба, хэлтсийн дарга нар солигдсон, нэрс буруу бичигдсэн гэдэг үндэслэлээр буцаах үзэгдэл гарсан. Гэвч МИТБМАЭ-ийн тухай хуульд тухайн мэдээллийг буцаах хоёр үндэслэлийг хуульчилсан байдаг. Тухайлбал, тус хуулийн 13.2.1-д “хүсэлт нь энэ хуулийн 11.3-т заасан шаардлагыг хангаагүй” (11.3 дахь шаардлагад мэдээлэл хүсэгчийн овог нэр, утасны дугаар, оршин суугаа газрын шуудангийн хаяг, иргэний үнэмлэх, гарын үсэг зурсан байх. Мэдээлэл хүсэгч хуулийн этгээдэд ч мөн ялгаагүй). 13.2.2-т “хүсэлтэд дурдсан мэдээлэл тухайн байгууллагын эзэмшилд байхгүй бөгөөд хүсэлтийг холбогдох байгууллагад шилжүүлэх боломжгүй” тохиолдолд л зөвхөн буцаахаар заасан байна.

МИТБМАЭ-ийн тухай хуулийн 9 дүгээр зүйл “Төсөв, санхүүгийн ил тод байдал”, 10 дугаар зүйл “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал” заалтуудыг хүчингүйд тооцож, 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Шилэн дансны тухай хуулиар илүү нарийвчлан зохицуулах болсон. Шилэн дансны хуулиар зохицуулахгүй бусад төсөв, худалдан авах ажиллагаатай холбоотой зохицуулалт нь хүчин төгөлдөр үйлчилнэ.

ХЗДХЯ-наас боловсруулж, УИХ-ын 2021 оны хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад Нийтийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн

төслүүдийг оруулж, өргөн барьсан.¹² Эдгээр хуулиуд батлагдсанаар МИТБМАЭ-ийн тухай хуулийг хүчингүйд тооцох юм. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар нийтийн албан тушаалтнууд ашиг сонирхлын мэдүүлгээ, Авлигын эсрэг хуулиар өөрийн болон гэр бүлийнхээ хөрөнгө, орлого, зээлийг мэдүүлэх үүрэг хүлээсэн тул энэ төрлийн мэдээлэл нээлттэй болж байна. 2018 онд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийг тус тус баталсан. 2019 оны Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар МИТБМАЭ-ийн тухай хуульд нийцүүлэн олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх зарчмыг зүйлчилсэн байна. Мөн ил тод, нээлттэй байх үүргийн хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг заавал байлцуулах, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр заавал түгээх тухай заалт орсон.

Дэлхий нийтэд дэгдсэн КОВИД-19 цар тахлын улмаас мэдээллийн урсгалыг хязгаарласан хууль тогтоомжууд батлагдан хэрэгжиж эхлэв. Тухайлбал, УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд дээрх асуудлаар хэд хэдэн заалт орсон байна. Үүнд:

9.13. Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

12.3. Цар тахал түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл түгээхийг хориглоно.

13.3. Цар тахал түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл түгээхийг хориглоно хэмээн тус тус заажээ.

Уг хууль батлагдсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4 дүгээр зүйлийн 10.4.13 дахь хэсэгт “олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч

¹² <https://mojha.gov.mn/>

хэрэгжүүлэх” гэж заасан. Харин Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 5.13.1 дэх хэсэгт “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн бол 5.13.3 дэх хэсэгт “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас өгсөн мэдээ, мэдээллийг үнэ төлбөргүйгээр, саадгүйгээр мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан.

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газраас ГИТ-д ирүүлсэн 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 1/2298 тоот албан бичигт дурдсанаар, Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 5.13.1 дэх хэсэгт заасан зөрчлөөр 2020 онд нийт 606 гомдол, мэдээлэл хүлээн авснаас газар дээр хялбаршуулсан 102, бүртгэлд авч хялбаршуулсан 436, зөрчлийн хэрэг нээсэн 68 зөрчил байгаагаас сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтанд холбогдох 2 зөрчилд шийтгэл оногдуулсан байна. Харин 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар Зөрчлийн хуулийн 5.13.1 дүгээр зүйлээр 9 гомдол, мэдээлэл хүлээн авснаас газар дээр хялбаршуулсан 1, бүртгэлд авч хялбаршуулсан 1, зөрчлийн хэрэг нээсэн 4 зөрчил байгаагаас сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтанд холбогдох 1 зөрчилд шийтгэл оногдуулжээ. Харин 5.13.3 заалттай холбоотойгоор 2020 онд гомдол, мэдээлэл ирээгүй бол 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 5 гомдол, мэдээлэл ирснээс зөрчлийн хэрэг нээсэн 4 зөрчил байгаагаас сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтанд холбогдох нэг зөрчилд шийтгэл оногдуулсан гэжээ.

Цагдаагийн ерөнхий газраас 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Худал мэдээлэлтэй тэмцэх нэгж байгуулснаа¹³ олон нийтэд зарласан. Хэвлэл мэдээллийн эрхчөлөөний тухай хуулиар “...Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй”, “Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, нэвтрүүлэх мэдээлэлд хяналт тавих байгууллага байгуулахгүй бөгөөд ийм хяналтын үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй” гэсэн заалттай тус нэгжийн чиг үүрэг, үйл ажиллагаа зөрчилдөхөөр байна. Худал мэдээлэл тараахтай холбоотой хуулийн нарийвчилсан тайлбар байхгүйн улмаас үүнтэй холбоотой зүйл заалтыг урвуулан ашиглах, хэтрүүлэн хэрэглэх, иргэд болон сэтгүүлчдэд хариуцлага оногдуулах зорилгоор гомдол, мэдээлэлд үндэслэлгүйгээр дур мэдэн мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрсдлийг

¹³ <https://mojha.gov.mn/newmojha/?p=4205>

бий болгож байна. Мөн дээрх хуулиудыг хэрэглэх явцад “олон нийтийг төөрөгдүүлэх”, “илт худал мэдээлэл” гэдэг нэр томъёоны нарийвчилсан тодорхойлолт байхгүйн улмаас эрх бүхий албан тушаалтан өөрийн үзэмжээр, дур зоргоор тайлбарлаж хэрэглэх зэргээр бэрхшээл тулгарч байна.

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор¹⁴ Эрсдэлийн мэдээллийн хороо байгуулсан. Улмаар Улсын онцгой комиссын дэргэдэх Эрсдэлийн мэдээлэл харилцааны түр хорооны бүрэлдэхүүнд Засгийн газрын 39 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж, холбогдох яам, агентлагийн газрын дарга нар болон МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн даргыг (зөвшилцсөнөөр) оруулсан. НҮБ тэргүүтэй олон улсын хүний эрхийн байгууллагуудаас улс орнуудыг цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ хүний эрхийн хэм хэмжээг баримтлахыг зөвлөсөөр байна. Тухайн зөвлөмжүүдэд улс орнууд хямралыг хор хохирол багатай даван туулахад нээлттэй яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, мэдээллийн чөлөөт урсгалыг хангах нь урьд урьдынхаас илүү шаардлагатай байгаа талаар онцлоод засгийн газрууд иргэддээ үнэн бодит мэдээллийг шуурхай, тогтмол хүртээмжтэй байдлаар хүргэх, интернэтийг блоклохгүй, хязгаарлахгүй байхын чухлыг онцолсон юм. Мөн түүнчлэн хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлахгүй, цагдан хяналт тогтоохгүй, холбогдох хуулиар хариуцлага тооцох аюул заналхийллээс сэргийлэх талаар сануулахаас гадна хүний эрхийг хамгийн бага хэм хэмжээгээр хөндсөн хууль, журам гаргахыг уриалж байна.

Засгийн газрын дээрх тогтоолын дагуу Түр хорооны үйл ажиллагааны чиглэл, ажил үүргийн хуваарь, Ажлын шуурхай хэсгийн ажиллах журмыг батлан мөрдүүлээгүй бөгөөд тус хорооны үйл ажиллагаа хэдий хугацааг хүртэл явагдах нь тодорхойгүй байна. Үүнээс гадна, уг тогтоолд үндэслэн мэдээлэл өгсөн иргэн, аливаа албан тушаалтанд хариуцлага тооцох зэргээр урвуулан ашиглах эрсдэл бий болж байна. Учир нь, тогтоолын 4 дэх хэсэгт “Түр хороо, Ажлын шуурхай хэсгийг үнэн зөв, бодит мэдээллээр тухай бүр хангаж, мэдээ, мэдээллийг зөвхөн нэг сувгаар, түр хорооноос өгөгдсөн чиглэлийн дагуу мэдээлж байх, нийтэд буруу ташаа, үндэслэлгүй мэдээ, мэдээлэл тараахгүй байх, тараасан бол холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг холбогдох сайд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай” гэсэн нь ямар хуулийн зүйл заалтаар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна.

¹⁴ <https://www.legalinfo.mn/law/details/16041>

1.4. СОНГУУЛЬ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

УИХ-аас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль /цаашид МУИХС-ийн тухай хууль гэх/, 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг баталснаар 2020 оны УИХ, орон нутгийн сонгуулиуд эрх зүйн орчны хувьд шинэ хууль тогтоомжуудаар зохицуулагдахаас гадна цартахлын үед явагдсанаараа онцлог байв. Мөн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдөр УИХ-аас Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсан.

МУИХС-ийн тухай хуульд орсон шинэ зохицуулалтад, 29.8-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно” гэсэн заалт, “Сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаа” бүлэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн “Сонгууль эрхэлсэн байгууллага, сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаа” гэсэн долдугаар бүлгүүд нь бүхэлдээ нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, түүний агуулгын хяналт, хэвлэмэл болон радио телевиз, цахим орчноор мэдээлэл түгээхтэй холбогдсон зохицуулалтыг оруулсан. Мөн “Сонгуулийн сурталчилгаа” бүлэгт өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх заалт багтсан. Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглахыг өмнөх сонгуулийн тухай хуульд тусгаснаас илүү дэлгэрүүлэн авч үзэв. Ингэхдээ цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтэлнэ /47.3/.

Түүнчлэн, тус хуулийн 48.7 дахь хэсэгт “Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно” гэж зааснаар анх удаагаа “хаалтын гэрээ”-г хориглосон зохицуулалт орсон юм. Бүх шатны сонгуулийн тухай хуулиудаар (Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиуд) нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа хэсэгт “Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглоно” гэсэн зохицуулалт шинээр орсон.

Сонгуулийн тухай дээрх хуулиуд батлагдсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар бүлэгт Улс төрийн эрх, эрх чөлөөний зөрчлийг

2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар шинээр нэмсэн. Энэ дагуу сонгуулийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хоёр саяас 200 сая хүртэлх торгуулийн шийтгэлийг Зөрчлийн тухай хуулиар оногдуулахаар хуульчилсан нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад эдийн засгийн цагдан хяналт тогтоох эрсдэл дагуулж байна. Нөгөө талаар, сонгуулийн жил бүрийн өмнө сонгуулийн эрх зүйн орчинд шинэчлэл хийдэг уламжлал тогтжээ. Ингэхдээ, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хараат бус, бие даасан мэдээ, нийтлэл түгээхийг хуулиар улам бүр хязгаарлаж, сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад хатуу хязгаарлалтуудыг тогтоож байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1-т “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэж заасан. Харин МУИХС-ийн тухай хуулийн 46.19-д хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан хариуцлага хүлээдэг байхаар тусгасан нь дээрх хуулийн заалттай зөрчилдөж байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд төрийн зүгээс аливаа цензур тавихыг хуулиар хориглосоор атал сонгуулийн үеийн хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо хүчингүй болгохоор заасан. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Харилцаа холбооны зохицуулах хорооноос хяналт тавих зэргээр төрийн зүгээс цензур тавих явдал байсаар байна.

МУИХС-ийн тухай хуулийн 46.12-т Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх радио, телевиз нь сонгуульд оролцогч бүх нам, эвсэл, нэр дэвшигчид тэгш хандах үүрэгтэй гэж заасан. Гэвч 2020 оны УИХ-ын сонгуульд өмнөх жилүүдээс олон 208 бие даагч нэр дэвшсэн нь сонгуулийн хуулийн энэхүү заалт бүрэн хэрэгжихэд хүндрэл дагуулсныг ГИТ-өөс сонгуулийн үеэр нэр бүхий таван телевизэд хийсэн мониторингийн дүнгээс¹⁵ харж болно.

Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн тухай хуулиуд батлагдсантай холбоотойгоор хэд хэдэн журам боловсруулан баталсан. Тухайлбал, “Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам”, “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ыг батлаж, ХЗДХЯ-нд хэм хэмжээний актаар бүртгүүлсэн байна. Энэхүү журмууд нь 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр мөн адил хэрэгжинэ.

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2019 оны 5 дугаар сард Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд сонгуулийн санал хураалт эхлэхийн өмнө сурталчилгаа

¹⁵ https://www.gic.mn/public/docs/publications/media_monitoring_20210412.pdf

дуусахаас өмнө гарсан гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зохицуулалт хийж байгаа талаар танилцуулсан.¹⁶ Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.8-д “Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно” гэж заасан бөгөөд 2019 онд нэмсэн 10 дугаар зүйлд “Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ” гэж тусгасан¹⁷ бөгөөд 2020 оны сонгуулийн үеэр уг заалтыг анх удаа дагаж мөрдсөн юм. Энэ нь сонгуулийн жилд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага “худал мэдээлэл тараах”, “сонгуулийн үеэр худал мэдээлэл тараах” зөрчил гаргасан эсэх асуудлыг Хэвлэл мэдээллийн зөвлөл бие даан шийдвэрлэх тохиромжтой механизм болохыг илтгэж байна.

1.5. НЭР ТӨР ГУТААХТАЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсад иргэний нэр төр, алдар хүндийг Иргэний хууль болон Эрүүгийн хуулиар хамгаалдаг.

А. Эрүүгийн хуулиар

2017 оны долдугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар “Гүтгэх”, “Доромжлох” гэсэн хоёр зүйл ангийг хассанаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөг дэмжин хамгаалахад ахиц гарсан. Гэвч УИХ-аас баталсан 2020 оны нэгдүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Худал мэдээлэл тараахыг анх удаагаа гэмт хэрэгт тооцон хуульчилсан. Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.14 дэх хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” гэж заасан. Худал мэдээлэл тараах гэмт хэргийг өөрчлөн найруулахаар УИХ-ын нэр бүхий гурван гишүүнээс Эрүүгийн

¹⁶ “Хэвлэлийн мэдээллийн зөвлөл: Ёс зүйн зарчимд шинэ заалт нэмэгдлээ”. 2019.05.02 <https://news.zindaa.mn/2ps3>

¹⁷ Хэвлэл мэдээллийн зөвлөл. Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг. Улаанбаатар, 2020 он. 18 дахь тал

хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийг 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр УИХ-д өргөн барьсан.

Эрүүгийн хуульд Худал мэдээлэл тараах гэмт хэрэг шинээр хуульчлагдсантай холбоотойгоор 2020 онд 258 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас хэрэг бүртгэлийн хэргийг хааж шийдвэрлэсэн 181, хэрэгсэхгүй болгосон 1, шүүхэд шилжүүлсэн 24 байгаа тухай Монгол Улсын Ерөнхий Прокурорын газраас ирүүлсэн албан тоотод дурджээ. Үүнээс яллагдагчаар татсан хүний тоо 29 бөгөөд шүүхээр орж шийтгүүлсэн хүний тоо 17 байна.

Мөн өнгөрсөн сонгуулийн үеэр хэрэгжсэн нэг заалт бол Эрүүгийн хуулийн “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараасан бол 450-5400 төгрөгтэй тэнцэх хэмжээний нэгжээр торгох, эсхүл 240-720 цаг нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэлтэй” гэсэн 14.8 дугаар зүйл юм. Энэ төрлийн гэмт хэрэгт 2020 онд Прокуророос яллах дүгнэлт үйлдэж, шүүхэд шилжүүлсэн тохиолдол гараагүй нь сайшаалтай.

Б. Иргэний хуулиар

Иргэний хуулийн 497 дугаар зүйлд зааснаар “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй”. Мөн хуулийн 511 дүгээр зүйлд зааснаар “Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ”. Нэр төр сэргээлгэх тухай Иргэний хуулийн зохицуулалтын нэг зөрчилтэй тал нь нийтийн албанд хамаарах байгууллагад нэр төр сэргээх боломж олгодогт байна. Өөр нэг тулгамдсан асуудал нь Иргэний хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан бол түүнийхээ “бодитой”, “үнэн зөв” гэдгийг нотлохыг мэдээ тараагчид ногдуулсан.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаахыг хориглосон зохицуулалт Сонгуулийн тухай хуулиудаас гадна УИХ-аас 2021 оны дөрөвдүгээр сард шинээр баталсан Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд орсон. Тухайлбал, уг хуулийн 8.1.3-д “Хүний эрх хамгаалагч нь бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаах”-ыг хориглоно гэж заасан. ХЭХЭЗБ-ын тухай хууль “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн №15(1165) дугаарт албан

ёсоор хэвлэгдээгүй, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем legalinfo.mn сайтад байршаагүй байв. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос УИХ-д өргөн барьсан төслийн 5.1.5-д “бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх” нь хүний эрх хамгаалагчийн үндсэн зарчим байхаар тусгаснаас бус хориглох зохицуулалтыг уг төсөлд заагаагүй байв.

Хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон олон улсын хуулиар хамгаалдаг. Тухайлбал, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13-д “халдашгүй чөлөөтэй байх эрхтэй.... нэр төрийг нь доромжилж болохгүй....”, 17 дугаар зүйлийн 2-д “хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх” үүрэгтэй байхаар заасан. Харин ИБУТЭОУП-ын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан 19 дүгээр зүйлд уг эрхийг бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх шаардлагаар хязгаарлаж болохоор заасан.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1998 оны А/RES/53/144 тогтоолоор “Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тухай тунхаглал” (Хүний эрхийг хамгаалагчийн тухай тунхаглал)-ыг батласан. Уг тунхаглал хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагаанд бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдахыг хориглосон зохицуулалт агуулаагүй байна. ХЭХЭЗБ-ын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд хүний эрх хамгаалагчийн нэр төрийг гутаах үйлдэл ихээр гарч байгаа талаар дурдсан болохоос хүний эрх хамгаалагчид нь бусдын нэр төрд халдахгүй байх зарчим, үүрэгтэй байхаар хориглосон санкцийн төрлийг нэрлэн заагаагүй. ХЭХЭЗБ-ын тухай хуулийн төслийн зорилтод “хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, хамгаалах, үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангах” гэсэн боловч ХЭХЭЗБ-ын тухай хуулийн 8.1.3 дахь заалтад бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаахыг хориглохоор заасан нь тус хуулийн зорилтод нийцэхгүйгээс гадна түүний хүрэх зорилго, үр дүнг хумихаар байна. Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон холбогдох олон улсын гэрээ, конвенцын дагуу бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдахгүй байх нь иргэн бүрийн үндсэн үүрэг. Иймээс, ХЭХЭЗБ-ын тухай хуулиар бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдах үйлдлийг хориглохоор тусгайлан заах гарцаагүй шаардлага байхгүй. Ингэж зааснаар, хүний эрх хамгаалагчийн хууль ёсны үйл ажиллагаанд хориг саад бий болгох, тэднийг айлган сүрүүлэх, цагдан хяналтын нэг хэлбэр болох, уг заалтыг тэдний эсрэг урвуулан ашиглах сөрөг нөлөө үүсэж болзошгүй.

1.6. АГУУЛГЫН ХЯЗГААРЛАЛТ

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Хүүхдийн эрхийн тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Хүн худалдаалахтай тэмцэх, Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн тухай зэрэг олон хуульд агуулгын хязгаарлалтыг тогтоосон. Эдгээр хязгаарлалт нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хийгдсэнийг бид хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч нэр томъёоны хувьд хэт ерөнхий, нарийн тодорхойлолт байхгүй, хамрах хүрээг тогтоогоогүй байдал нь хязгаарлалтыг хэтрүүлэх нөхцөл үүсгэж болзошгүй. Үүнээс гадна, чөлөөт шүүмжлэл өрнүүлсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагаанд хэтийдсэн хязгаарлалт тогтоож ч болохоор эрсдэл дагуулж байна.

2016 оны хоёрдугаар сарын 5-ны өдөр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн “Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал” хэмээх 8 дугаар зүйлд хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаалах, хүүхэд хамгаалах зөвлөмж, зааварчилгааг олон нийтэд тогтмол мэдээлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах зохицуулалт орсон нь ИБУТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн нийгмийн дэг журмыг хангах үүднээс хуулиар тогтоосон, зайлшгүй хязгаарлалтын тухай заалтад нийцэж байна.

Манай улсын хууль, тогтоомжид төрийн мэдээллийг заавал дамжуулах үүргийг ногдуулсан хэд хэдэн хуулийн заалт бий. Үүнийг дотор нь түгээхэд болон агуулгад тавих үүрэг, хязгаарлалт гэж хоёр ангилбал:

Түгээхэд үүрэг оногдуулах

- Урьдчилан сэргийлэх мэдээг радио, телевиз болон мэдээллийн бусад хэрэгслээр түүнийг хүлээн авснаас хойш 15 минутын дотор тусгай дуут болон дүрсийн дохиотойгоор нийтэд үнэ төлбөргүйгээр шуурхай мэдээлнэ; /Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 15.2/
- Хэвлэл мэдээллийнхэн дайн эхэлсэн буюу дууссан тухай зарлах ёстой; /Дайны байдлын тухай хуулийн 5.4, болон 6.3/
- Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна; /Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.5/

- Шуурхай мэдээлэл нийтэд түгээх шаардлага гарсан тохиолдолд өмчийн харьяалал харгалзахгүйгээр хэвлэл, мэдээлэл, холбооны хэрэгсэл ашиглах; /Цагдаагийн албаны тухай 59.1.2/
- Залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах; /Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.1.5/
- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хог хаягдлын талаарх үндэсний уламжлал, зан заншил, тэргүүн туршлага, хууль тогтоомжийг сурталчлах; /Хог хаягдлын тухай хуулийн 42.2.3/
- Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас өгсөн мэдээ, мэдээллийг үнэ төлбөргүйгээр, саадгүйгээр мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. /Зөрчлийн тухай хуулийн 5.13.3/
- Цар тахал түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээлэл түгээхийг хориглоно; /Коронавируст халдвар Ковид-19-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 12.3/
- Цар тахал түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахтай холбоотой олон нийтийг төөрөгдүүлэх, мэдээлэл түгээхийг хориглоно; /Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13.3/
- Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй; /Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16.3/
- Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, түүний эсрэг авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар зарлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол, шуурхай, хүртээмжтэй, дэлгэрэнгүй мэдээлэх; /Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26.1.5/
- Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон болон аюулын нөхцөл байдлын талаар хүн амд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, эсхүл шууд мэдээлэх, заавар, зөвлөмжөөр хангах; /Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29.1.5/

- Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээх үүрэгтэй;¹⁸ /Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 41.19/
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа тогтмол явуулах; /Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 33.1.4/

Хэвлэл мэдээллийн байгууллагад тодорхой төрлийн мэдээлэл дамжуулах үүрэг хүлээлгэх нь шаардлагагүй бөгөөд зарим тохиолдолд үүнийг урвуулан ашиглаж болно. Тухайлбал, бие даасан ХМХ-ийг дээрх тодорхой бус заалтыг хэрэгжүүлээгүй гэдэг үндэслэлээр дарамтлах, хаах явдал ч гарч болзошгүй. Бусад ардчилсан оронд ийм шаардлага тавих нь ховор байдаг боловч хэвлэл мэдээлэл нь нийтийн ач холбогдолтой асуудлыг хангалттай мэдээлдэг. Иймээс, мэдээллийг өргөн түгээх явдлыг үүрэг болгож ногдуулах бус харин бие даасан, хараат бус, олон ургальч хэвлэл мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх нь илүү үр дүнтэй. Нөгөөтээгүүр, төрийн байгууллагууд мэдээлэл дамжуулах эрхээ хэтрүүлэн ашиглаж болзошгүй. Европын Зөвлөлийн Сайд нарын хороо хувийн хэвлэл мэдээллээс илүү үүрэг хүлээх ёстой төрийн хэвлэл мэдээлэлд “заавал нэвтрүүлэх” үүрэг оногдуулахаас болгоомжилдог. Олон нийтийн өргөн нэвтрүүлэг зөвхөн хуулиар тогтоосон онцгой нөхцөлд албан ёсны мэдээ, мэдэгдэл, мэдээллийг нэвтрүүлэх эсхүл төрийн байгууллагаас гарсан шийдвэрийг мэдээлэх ба төрийн байгууллагад эфирийн хугацааг ийм зорилгоор олгох ёстой гэж заасан.¹⁹ Олон нийтэд түгээх мэдээ нь тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын редакторын шийдвэрлэх асуудал бөгөөд хуулийн шаардлага байх ёсгүй.²⁰

Төрөөс хэвлэл мэдээлэлд эрх зүйн үндэслэлгүй хязгаарлалт хийдэггүй бөгөөд Монгол Улсад сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд ямар нэг хориг, саад байхгүй. Парламентын болон шүүхийн сурвалжилга хийх сэтгүүлчдээс зөвхөн албан ёсны үнэмлэх шаарддаг. Сонгуулийн ерөнхий хорооны 2013 оны 22 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан сонгуулийн үйл ажиллагааг сурвалжлах журам”-ын дагуу сонгуулийн үйл явцыг сурвалжилж буй сэтгүүлчдэд тус хорооноос үнэмлэх олгох ба энэ нь ажлын үнэмлэхийн хамт хүчинтэй байхаар тусгажээ. Мөн 1995 онд батлагдсан Онц байдлын тухай хуульд Засгийн газар “...олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг

¹⁸ Бүх шатны сонгуулийн тухай хуулиудаар уг заалтыг үүрэг болгож оруулсан.

¹⁹ Зөвлөмж №:R (96) 10, тэмдэглэл 44.

²⁰ “Монгол Улс шилжилтийн үед: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон мэдээллийн эрх чөлөөнд нөлөөлж буй Монгол Улсын хуулиудад хийсэн задлан шинжилгээ”, (2002 он), 59 дэх тал

цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох” эрхтэй гэж заасан нь төрөөс хэвлэн нийтлэх эрх чөлөөнд цагдан хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж буйн нэг жишээ юм.

Соёлын тухай хуульд 2015 оны 2 дугаар сарын 12-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ өөрчлөлтөөр “Соёлын хүрээнд төрийн болон бусад байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт” гэсэн (19) зүйлд нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэ зохицуулалтын гол агуулга нь үндэсний нэвтрүүлгийг дэмжих төрийн бодлоготой уялдаж байгаа ч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт учруулж болзошгүй үүрэг ногдуулалт юм. Зөвхөн улсын байцаагчийн шийдвэрээс хамаарч олон нийтийн оролцоо, хяналт байхгүй явдал нь урвуулах, хэтрүүлэн ашиглах боломжийг төрд олгож байна.

Агуулгад тавих хязгаарлалт

Монгол Улсын хэд хэдэн хуульд нийтлэх болон нэвтрүүлэх зүйлийн агуулгад хязгаарлалт тавьсан. Ихэнх тохиолдолд хуулиар хууль ёсны зорилгыг хамгаалдаг. ИБУТЭОУП-ын 20 дугаар зүйлээр дайныг сурталчлах, алагчилан дайсагналцах, хүчирхийллийг өдөөн турхирах, арьс өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зэргийг хориглохоор заасан. Гэхдээ үүнийг хэт өргөн эсхүл хэт бүрхэг тодорхойлдог учраас буруугаар хэрэглэх нөхцөл бүрдүүлэх эрсдэлтэй. Садар самууныг сурталчлахыг хориглосон заалт хэд хэдэн хуульд орсон. Үүнд:

- Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол; /Эрүүгийн хуулийн 16.8/
- “Садар самууныг сурталчлах” гэж бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг; /Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 3.1.1/
- Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол; /Эрүүгийн хуулийн 16.9/
- Дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, соёлд хор хохирол учруулах соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглоно; /Соёлын тухай хууль 19.3/

- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно; /Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 5.1/
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүчирхийлэл, аллага хядлага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг өөгшүүлэн сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх, түүний ул мөрийг нуун далдлах арга, хэрэгслийг нарийвчлан дүрсэлсэн, гэмт хэрэг, зөрчлийг ашиг, орлогоо нэмэгдүүлэх хэрэгсэл болгон харуулсан, гэмт хэрэг, зөрчил үйлдэх сэдэл төрүүлж болох агуулгатай аливаа мэдээллийг нийтлэх, нэвтрүүлэхийг хориглоно; / Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 32.6/
- Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно; /Зөрчлийн тухай хуулийн 5.13.1/
- Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана; /Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9.13/
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа шүүх, шүүгчийн нэр хүндэд харшилсан, эсхүл шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл, зураг, дууны, дуу-дүрсний бичлэг болон бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл тараах, байршуулах; /Шүүхийн тухай хуулийн 50.1.32/
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хэргийн талаар мэдээлэл өгөх / Шүүхийн тухай хуулийн 60.1.6/

1.7. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

Хэвлэл мэдээллийн өмчлөл ба төвлөрөл

2010 онд баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх” тухай заалт анх удаа тусгагдсан юм. 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

батлагдсан Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт “Өргөн нэвтрүүлгийг хараат бус, нээлттэй, ёс зүйтэй байлгах зорилгоор өргөн нэвтрүүлгийн эзэмшлийг ил тод байлгана”, мөн 30 дугаар зүйлийн 30.1.2 хэсэгт “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийг олон нийтэд ил тод мэдээлэх, хэт төвлөрөл бий болохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх” гэж Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх үүрэгт заажээ.

Монгол Улсад бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүртгэлтэй байх ёстой бөгөөд байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор бүртгүүлэх өргөдлөө гаргах үүрэгтэй. Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг үндэслэн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх нь зүйн хэрэг. Монгол Улсад хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл ашгийн болон ашгийн бус гэсэн хоёр үндсэн төрөлтэй хэдий ч хуульд өмчлөлийн олон талт байдлыг тусгаагүй. Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл (community media)-ийн бодлого, зохицуулалтыг аль ч түвшинд хүлээн зөвшөөрөөгүй байна. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар шашны байгууллагад өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон нь хүйн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хязгаарласан зохицуулалт болсон. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.16.1 дэх хэсэгт заасны дагуу радио телевизийн байгууллага нь зөвхөн тусгай зөвшөөрөл авсны дараа бүртгүүлэх ёстой. Харин тусгай зөвшөөрөл авахын тулд тухайн засаг захиргааны Засаг даргын саналыг авах шаардлагагүй болгож, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар зохицуулах болсон юм.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар эзэмшил, төвлөрлийн асуудлыг хуульчилсан нь сайшаалтай хэрэг юм. Өмнө нь журмаар зохицуулж байсан харилцааг хуулиар зохицуулах болсон нь хамгийн том дэвшил байв. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эзэмшлийг олон нийтэд ил тод мэдээлэх, хэт төвлөрөл бий болохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх нь ХХЗХ-ны үүрэг юм. Мөн тус хуулийн 7.4.3-д “радио, телевизийн газрын тоон сүлжээний үйлчилгээ болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг радио, телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй давхардуулан олгохгүй, эзэмшил нь тусдаа байх”-ыг зохицуулсан зэрэг сайшаалтай талууд харагдаж байна. Хэвлэл мэдээллийн эзэмшил, харьяалал нь компани, хувь хүмүүсийн өөр өөр нэр дээр бүртгэгдсэн тул жинхэнэ эзэмшигчид нь ил тод бус, борлуулалтын мэдээлэл болон хэрэглэгчдийн зах зээлд эзлэх хувийг нууцалдаг учир төвлөрлийг бодитоор тогтоох боломж хомс байна.

2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь хэсэгт хэвлэл, мэдээлэл, харилцаа холбооны салбарт

үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авахаар зохицуулсан. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд төрийн өмчлөлийг хориглосон ч сүүлийн жилүүдэд орон нутгийн засаг захиргаа үйл ажиллагаа, бодлогоо сурталчлах телевиз, сонин олноор байгуулж, хууль зөрчиж байна. Хэвлэл мэдээллийн өмчлөл нууц байх, хэвлэл мэдээлэл нэг гарт төвлөрөх нь редакцын цензурыг өөгшүүлж, ингэснээр хэвлэлийн эрх чөлөөг хумих, олон ургальч үзлийг сааруулах, сэтгүүл зүйн мэдээллийн чанарт сөргөөр нөлөөлөхөөр байна.

Хэвлэл мэдээллийн зах зээл бүрэн төлөвшөөгүй, хэвлэл мэдээллийн байгууллагууд зар сурталчилгааны орлогын төлөө шударга өрсөлдөхөөсөө илүүтэйгээр төрийн байгууллага, улс төр, бизнесийн байгууллагатай гэрээ хийж, үйл ажиллагаа явуулах тохиолдол түгээмэл байна. Мэргэжлийн байгууллагуудын судалгаанаас харахад, манай улсад хэвлэл мэдээллийн эзэмшлийн ил тод байдал болон хэвлэл мэдээллийн төвлөрлийн талаар тухайлсан хууль тогтоомж байдаггүй. 2016 онд Хэвлэлийн хүрээлэнгийн “Хил хязгааргүй сурвалжлагчид” олон улсын байгууллагатай хамтран хийсэн судалгаагаар Монголын хамгийн их хүртээмжтэй, үзэгч сонсогчдын таашаадаг хэвлэл мэдээллийн хэрэгслийн дийлэнх буюу 74% нь улс төрчид, нийтийн албан тушаалтан, улс төрд ойр байдаг бизнесийн бүлгүүдийн мэдэлд байна. Түүнчлэн 39 хэвлэл мэдээллийн хэрэгслээс 29-ийнх нь эзэн, хөрөнгө оруулагч улс төрийн ямар нэгэн хамааралтай байгаа талаар дурджээ.²¹

ХААЛТЫН ГЭРЭЭ

Монголын хэвлэл мэдээллийн салбарт нуугдмал олон асуудал байгаагийн нэг нь редакцын цензур буюу цагдан хяналт юм. Өмнөх судалгаанд оролцогчид тэдний ажилладаг редакцид хаалтын гэрээ бий эсвэл бусад шалтгаанаар бичихийг хориглосон сэдвийн “хар жагсаалт” байдаг гэдгийг тэдний 40 хувь нь хүлээн зөвшөөрсөн байдаг. Мөн 2018 онд хийсэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдлын түвшин тогтоох” судалгаанд 300 сэтгүүлчийг хамруулснаас тэдний 52% нь редаксаас зарим асуудалтай холбоотойгоор нийтлэл, нэвтрүүлгийг нь хориглосон тухай дурджээ.

Үүнээс үзэхэд, хэвлэл нийтлэх эрх чөлөөний хамгийн тулгамдсан асуудлын нэг “хаалтын гэрээ” болж байна. Гэвч “хаалтын гэрээ” хэмээх тухайлсан гэрээ байдаггүй бөгөөд сурталчилгааны гэрээ, хамтран ажиллах

²¹ <https://mongolia.mom-rsf.org/mn/translation-context/translation-media-market/>

гэрээ дотор байдаг ганцхан заалтыг нэрлэж болно. Тухайлбал, “захиалагч талын нэр хүндэд харшлах аливаа сөрөг мэдээ, мэдээллийг захиалагч талд мэдэгдэх, нэвтрүүлэхгүй байх үүрэг хүлээнэ” гэдгийг “хаалтын гэрээ” хэмээх нэр томъёогоор ойлгож болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хаалтын гэрээ байгуулах нь хэвлэл мэдээллийн тэнцвэртэй, чөлөөт, олон ургалч, хараат бус байх зарчимтай үл нийцнэ. УИХ-ын Сонгуулийн тухай хуульд хаалтын гэрээг анх удаагаа хориглосон. Тухайлбал, Сонгуулийн тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.7 дахь хэсэгт “Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно” гэж заасан нь хаалтын гэрээ байгуулахыг хориглож байгаа явдал юм. Хэрэв энэхүү үүргээ зөрчвөл, Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 17.1.19-д зааснаар иргэнийг 20 сая төгрөгөөр, хуулийн этгээдийг 200 сая төгрөгөөр торгоно. Гэхдээ энэ нь зөвхөн сонгуулийн үеэр хүлээлгэх хариуцлага юм.

Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 2/5569 албан тоот бичигт энэ төрлийн гомдол, мэдээлэл нэг иргэнээс ирүүлснийг шалгаснаас, зөрчлийн шийтгэл оногдуулаагүй тухай дурджээ. Хаалтын гэрээтэй холбоотой Иргэний хэргийн шүүхэд маргаан одоогоор хянан шийдвэрлээгүйг эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем shuukh.mn цахим хуудаснаас харж болно.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд аливаа хэлбэрийн хаалтын гэрээ байгуулах нь эдийн засгийн хараат байдалд оруулдаг. Байгууллагын удирдлага нь тухайн хамтран ажиллагч этгээдийн эсрэг мэдээ, мэдээлэл нийтлэхгүй байх, тийм мэдээлэл бэлтгэсэн сэтгүүлчийн мэдээ, материалыг засварлах, бүр цаашлаад хориглох тохиолдол гардаг учир энэ нь сэтгүүлч, редакцын хараат бус, бие даасан мэргэжлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар аливаа хэлбэрийн цагдан хяналт буюу цензурыг хориглосны дотроос 3 дугаар зүйл 3.1 дэх хэсэгт “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй”. Энэхүү заалтад бүх төрлийн цензур хамаарна. Засгийн газраас хэвлэл мэдээллийн зарим байгууллагуудтай “хамтран ажиллах” гэрээ байгуулж байгаа нь төрийн хяналт цензурыг тогтоох эрсдэлтэйгээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтийн эрх ашигт нийцсэн мэдээ, мэдээлэл бэлтгэх үүргээ умартахад хүргэх сөрөг талтай. Мөн чанараараа чөлөөт хэвлэл мэдээлэл нь олон нийтийн үнэнийг мэдэх зарчимд үйлчилдэг, тэнцвэртэй, хараат бус байх ёстой бөгөөд аль нэг талын дагнасан зар сурталчилгаа, тэнцвэргүй мэдээ, мэдээлэл түгээх нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх биш юм.

ИНТЕРНЭТ БУЮУ ЦАХИМ ОРЧИН

Монгол Улсад интернэт хэрэглэгчдийг дотоод, гадаадын аль ч сайтад нэвтэрч, нийгмийн сүлжээнд нэгдэж, харилцахыг төрөөс хязгаарласан зохицуулалт байхгүй. Нөгөө талаар, 2020 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Цагдаагийн ерөнхий газар болон ХХЗХ-ны дарга нарын хамтарсан А/200, А/169 дугаар тушаалаар цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тараахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг батлан, хэрэгжүүлж байна. Тус журмаар цар тахлын үед нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээллийг устгах, эсхүл хандалтыг хязгаарлах тухайн цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн Монгол Улсаас хандах хандалтыг цар тахал намдах хүртэл хугацаагаар хязгаарлах зохицуулалт орсон.

Дээрх журам батлагдсантай холбоотойгоор ХХЗХ-ноос интернэтийн үйлчилгээ эрхлэгчдэд харилцаа холбооны үйлчилгээний бэлэн байдлыг хангах тухай 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 04/1981 албан тоот хүргүүлж, тус журмыг мөрдөн ажиллахыг 290 цахим сайтын үйлчилгээ эрхлэгчдэд анхааруулсан. Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг ийнхүү нийтлэг байдлаар хязгаарлаж буй нь бүх нийтийн эрүүл мэндийг цар тахлаас хамгаалах зорилгод гарцаагүй шаардлагатай гэж үзэх хууль зүйн үндэслэл хангалттай бус. Мөн түүнчлэн, Засгийн газрын 2020 оны 3 дугаар дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаас гарсан чиглэлийн дагуу цар тахалтай холбоотой албаны мэдээ, мэдээллийг хэрэглэгчийн сэтгэгдэл авах боломжгүй тохиргоотойгоор нийтлэх зөвлөмжийг ХХЗХ-ноос мөн өдөр 134 цахим сайтын үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн²². Энэхүү чиглэлийн дагуу захиргааны хэм хэмжээний актаар бүртгэсэн тогтоол, захирамж одоогоор гараагүй тул заавал дагаж мөрдөх хууль зүйн үүрэг цахим сайтын үйлчилгээ эрхлэгчдэд байхгүй. Журмын 4.1.1-д “цахим орчинд цар тахлын үед нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээ, мэдээлэл тарааж байгаа цахим орчинд хязгаарлалт хийх хүрээнд хамтран ажиллах төлөөлөгч томилж, овог, нэр, албан тушаал, хөдөлгөөнт болон суурин утасны дугаар, цахим шуудангийн хаягийг Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлэх” гэж заасан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн “Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй”, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно” гэсэн хуулийн заалтуудтай зөрчилдөж байна.

Олон улсын хэм хэмжээгээр хэвлэл мэдээллийн ажилтнуудад тусгай зөвшөөрөл олгох, бүртгэхийг хориглодог. НҮБ-ын Хүний Эрхийн Хорооны

²² Харилцаа холбооны зохицуулах хорооны цахим сайт, цахим сайтын үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлэх тухай мэдээлэл.

тодорхойлолтоор, “сэтгүүл зүй бол мэргэжлийн, бүтэн цагаар ажиллаж буй сурвалжлагч, шинжээч, мөн блогчид, хэвлэл болон интернэт, өөр бусад хэрэгслээр өөрөө хэвлэн нийтлэл эрхлэгчдийг хамарсан өргөн хүрээтэй, олон тооны тоглогчдын дунд хуваагддаг үйл ажиллагаа бөгөөд улсын бүртгэлийн ерөнхий тогтолцоо, сэтгүүлчдийг лицензжүүлэх нь ИБҮТЭОУП-ын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт үл нийцнэ. Хязгаарлагдмал итгэмжлэх үнэмлэх олгох нь тодорхой газар, үйл явдалд нэвтрэх давуу эрх олгож байгаагаар хүлээн зөвшөөрөгдөнө. Ийм зохион байгуулалт нь Пактын 19 дүгээр зүйл, бусад зүйл заалтад нийцсэн, үл ялгаварлах зарчим, бодит шалгуурт үндэслэгдэх бөгөөд сэтгүүл зүй бол өргөн хүрээтэй, олон тооны тоглогчдын дунд хуваагддаг үйл ажиллагаа болохыг анхааралдаа авах ёстой.”

Иргэд зохих шаардлага хангахгүй, эсхүл интернэт холболтгүй орчинд тусгаарлагдсанаар гэр бүл, найз нөхөдтэйгээ харилцах, мэдээлэл олж авах, цахим сургалтад хамрагдах зэрэг мэдээлэл, харилцааны боломж давхар хязгаарлагдаж байна. Тухайлбал, тусгаарлан ажиглах байрны бүх өрөөнд зурагт радио байхгүй, интернэтийн сүлжээ хурд багатай байгаа зэрэг нь иргэдийн мэдээлэл авах эрхийг хөндөж, бухимдлыг төрүүлж байгаа талаар ХЭҮК-ын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь удаагийн илтгэлд дурджээ.

Сонгуулийн тухай хуулиудаар цахим орчин ашиглах зохицуулалт хийсэн. Тухайлбал, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар ХХЗХ нь 46 дугаар зүйлийн 46.13, 46.19, 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.3, 47.3 дахь заалтуудад хяналт тавихаас гадна “Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1, 2 дугаар зүйлийн 2.2, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт хяналт тавих чиг үүрэгтэй байна. УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн хугацаанд эрх бүхий байгууллагууд болох ЦЕГ-аас 224, ШӨХТГ-аас 67, ТЕГ-аас 19, бусад газраас 15, нийт 325 санал, дүгнэлт ирүүлсний дагуу холбогдох үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч, интернэтийн үйлчилгээ эрхлэгч, цахим орчны үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн бөгөөд 138 санал, дүгнэлтэд холбогдох арга хэмжээг авсан байна.²³

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол улсад анхны өөрийн зохицуулалтын байгууллага болох Хэвлэл мэдээллийн зөвлөл 2015 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр албан ёсоор байгуулагдсан. Хэвлэл мэдээллийн зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах зөвлөл удирдах бөгөөд тус тус 15 хүний бүрэлдэхүүнтэй телевиз, радиогийн ёс зүйн хороо болон сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хороо,

²³ ХХЗХ-ны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын 2020.10.09-ний өдрийн 04/1767 тоот албан бичиг

мөн ажлын алба, гүйцэтгэх захиралтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Сүүлийн жилүүдэд ХМЗ-ийн үйл ажиллагаа өргөжин тэлж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас тус зөвлөлд өргөдөл гомдол гаргах нь нэмэгдэж байна. Тухайлбал, 2015 онд 19 хэвлэл мэдээллийн редакцад хаягласан өргөдөл гомдлыг хүлээж авч шийдвэрлэсэн бол 2018 онд 100, 2019 онд 106 хүлээн авч шийдвэрлэжээ. Харин КОВИД-19 цар тахлын хөл хорионы дэглэм хэрэгжиж байсан 2020 онд 52 өргөдөл, гомдол хүлээн авч, ёс зүйн хороодоор хэлэлцэн шийдвэрлэжээ. ХМЗ байгуулагдсан цагаасаа хойш иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас сэтгүүл зүйн ёс зүйн зарчмыг зөрчсөн гэж үзсэн нийт 404 гомдол /2021 оны 4 дүгээр сарын 13-ны байдлаар/ хүлээн авч, шийдвэрлэжээ. Үүнээс харахад, ХМЗ-өөр маргаанаа шийдвэрлүүлэх явдал нэмэгдэж байгаа нь нийгэмд өөрийн зохицуулалтын байгууллага хүлээн зөвшөөрөгдөж буйн илрэл юм. Хэвлэл мэдээллийн зөвлөл нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын дүрэм, Үйл ажиллагааны журам, Гомдол хүлээн авах, барагдуулах журам, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд тулгуурлан өргөдөл гомдлыг хэлэлцэж дүгнэлт гаргадаг.

ХМЗ-өөс өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдал:

2020 онд иргэд, байгууллагаас ирүүлсэн нийт 52 өргөдөл гомдлын дийлэнх буюу 81% нь сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хороонд хаяглагджээ. Гомдол хүлээн авах, барагдуулах журам (цаашид ГХАБЖ гэх)-ын 2.3-ийн дагуу 23 редакцад хаягласан гомдлыг хугацаа хэтэрсэн, материалаа бүрэн бүрдүүлж өгөөгүй, Зөвлөлийн чиг үүрэгт хамаарахгүй, гомдол үндэслэлгүй зэрэг шалтгаанаар тус Зөвлөлийн Ажлын албанаас урьдчилсан хяналт хийж шийдвэрлэсэн байна. Харин 9 редакцад хаягласан өргөдлийг гомдол гаргагч өөрөө буцаан татсан. 19 редакцын 22 бүтээлд хаягласан өргөдлийг хоёр Хорооны 6 удаагийн хуралдаанаар хэлэлцэж, ГХАБЖ-ын 6.3-ийн дагуу дараах дүгнэлтийг гаргасан. Үүнд:

- ГХАБЖ-ын 6.3.1 –ийн дагуу 7 редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчөөгүй гэдгийг олон нийтэд мэдээлэх;
- ГХАБЖ-ын 6.3.2-ын дагуу 3 редакцыг зөрчлөө өөрсдөө залруулсан, уучлал гуйсныг мэдэгдэж, нэрийг дурдахгүйгээр олон нийтэд мэдээлэх;
- ГХАБЖ-ын 6.3.3-ийн дагуу 9 редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчсөн тул нэрийг дурдаж олон нийтэд мэдээлэх тухай дүгнэлт гаргажээ.²⁴


²⁴ <http://www.mediacouncil.mn/>

ХОЁР

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ
ЧӨЛӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Глоб Интернэшнл төвөөс Нээлттэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ болох өндөржүүлсэн бэлэн байдал болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн 2020 оны 1 дүгээр сарын 27-ноос 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хугацаанд гарсан иргэний болон улс төрийн эрхийн зөрчилд, тухайлбал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдэх эрх, эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхийн зөрчилд мониторинг хийв. Мониторингийн хугацаанд давхардсан тоогоор иргэний болон улс төрийн эрхийн 76 зөрчил бүртгэв. Эдгээр зөрчлийн талаас илүү буюу 51 хувь нь мэдэх эрх, мэдээлэл авах, түгээх, боловсруулах эрхийн зөрчил байсан бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчил 32 хувь, эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхийн зөрчил 17 хувийг тус тус эзэлж байна.

График 1. Иргэний болон улс төрийн эрхийн зөрчлийн эзлэх хувь



Эндээс дүгнэхэд, КОВИД-19-ийн цар тахлын үед албан тушаалтнуудын зүгээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөөг ноцтой зөрчих явдал түгээмэл байна. Ийм төрлийн зөрчлийн талаар иргэд мэдээлж, эсэргүүцэхгүй бол энэ байдал далд хэлбэрт шилжих, улмаар хэвийн үзэгдэл

болох эрсдэлтэй. Дээрх төрлийн зөрчил олноор гарах болсон шалтгаан нь КОВИД-19 цар тахлын үед үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдэх эрхийг хамгаалсан хууль зүйн баталгаа хангалтгүй байгаагийн сацуу тийнхүү зөрчигдөхөөс сэргийлсэн бодит механизм бүрдээгүй байгаатай холбоотой.

Жишээ 1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчиж буй байдал

Зөрчлийн тухай хуулийн “Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих” гэх 5.13 дугаар зүйлийн 1-т “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед энэ талаар олон нийтийг төөрөгдүүлэх, худал мэдээ, мэдээлэл түгээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэх зохицуулалтаар цар тахлын үед үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийг шийтгэж байна. Дээрх зохицуулалтыг хэрэглэхдээ Монгол Улсын Засгийн газар, эрх бүхий байгууллагууд бүх хүнд хүртээмжтэй хэлбэрээр, бүрэн, хоёрдмол утгагүйгээр мэдээллийг цаг тухайд нь өгсөн эсэхийг огт харгалзахгүй байна. Түүнчлэн дээрх зохицуулалтад буй “олон нийтийг төөрөгдүүлэх”, “илт худал” гэх шалгуурыг хэрхэн хэрэглэх нэгдсэн ойлголт, эрх зүйн зохицуулалт үгүй тул түүнийг албан тушаалтнууд өөрийн дураар, харилцан адилгүй хэрэглэх, улмаар хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг өөрийн үзэмжээр эсхүл зориудаар хязгаарлах үр дагаварт хүргэж байна.

Жишээ 2. Мэдээлэл авах эрхийг зөрчиж буй байдал

Онцгой комиссын албан тушаалтнууд /УОК, НОК/-ын зүгээс хүндэтгэх шалтгаантай орон нутаг руу явах иргэнд 8 хоногийн турш нууцад хамаарахгүй, байнга ил байх ёстой мэдээллийг өгөөгүй, удаасан, харилцах утас, цахим шуудангийн хаягаа байнга өөрчилж байсан бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтнуудын хувьд хуучирсан мэдээллээ цаг тухайд нь шинэчлэхгүй байх, өөр хоорондоо нэгдсэн мэдээлэлгүй байгаа нь Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний мэдэх эрхийг зөрчих, улмаар мэдээллийг зохих хугацаанд нь бүрэн дүүрэн, ойлгомжтой хэлбэрээр өгөөгүйгээс иргэний эрүүл мэндийг хохироох, бусад хүндрэл бэрхшээл учруулж байна. Жишээлбэл, Архангай аймгаас “Эмээлт” авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд эрүүл мэндийн хүндэтгэх шалтгаантай иргэнийг хэрхэн нэвтрүүлэх, тухайн иргэн хэрхэн бэлтгэл хангах талаар мэдээлэл хүргээгүй, албан тушаалтнууд харилцан мэдээлэл солилцож чадаагүйн улмаас иргэний амь нас хохирсон харамсалтай хэрэг гарсан.

Иймд, КОВИД-19 цар тахал үргэлжлэх хугацаанд төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээлэлтэй байх эрх зөрчигдөхөөс сэргийлсэн хууль зүйн иж бүрэн баталгаа бүрдүүлэх, байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хүний эрхийн зөрчилд хүргэхгүй байх нөхцөлийг зайлшгүй харгалзах, ингээгүй тохиолдолд тухайн шийдвэр, үйл ажиллагааг хүчингүйд тооцож байх, түүнд тавих төрийн болон иргэний нийгмийн хяналтыг сайжруулах зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна. Ингэхийн тулд төрийн байгууллагын албан тушаалтнуудыг цар тахлын үед хүний эрхийн зарчмуудын тухай мэдлэг ойлголт нэмэгдүүлэх; холбогдох шийдвэр, хариу арга хэмжээг судалгаа тооцоон дээр үндэслэж хэрэгжүүлэх, дээд шаатны байгууллага, албан тушаалтнаас цар тахлын үед гарсан шийдвэрийг газар дээр нь хэрэгжүүлэх албан тушаалтнуудад зориулсан зөвлөмж, зааварчилгаа гаргаж байх; холбогдох шийдвэрийг гаргасны дараа бус гаргахаас өмнө тухай бүр ХЭҮК-оор хянуулж байх механизм бүрдүүлэх нь зүйтэй.

ЮНЕСКО зэрэг олон улсын байгууллагуудын зөвлөж байгаачлан, хууль сахиулах байгууллагын ажилтнууд цар тахлын үеэр дур зоргоороо баривчлах, саатуулахаас урьдчилан сэргийлэхийн тулд олон нийтийн эрх ашигт нийцсэн баталгаатай мэдээлэл хэвлэн нийтэлдэг сэтгүүл зүйн тоглогчид, бусад хүмүүст шаардлагатай хувь хүний халдашгүй дархан байдал, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай ойлголт мэдлэгтэй байх нь зүйтэй. Мөн түүнчлэн шүүх эрх мэдлийн хүрээнд, нэн ялангуяа шүүгчид дисинфодемик буюу хуурамч мэдээллийн цар тахалтай тэмцэх арга хэмжээтэй холбоотой хэргүүдийг шийдвэрлэхдээ тэдгээр нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хүний халдашгүй дархан байдлыг баталгаажуулж буй олон улсын хэм хэмжээг бүрэн хүндэтгэхийн төлөө онцгой анхаарах шаардлагатай.

Цар тахлын үед, ГИТ-өөс гадна бусад мэргэжлийн байгууллагууд хэвлэлийн эрх чөлөөний нөхцөл байдлын талаар судалгаа хийсэн. Тухайлбал, ХМЗ-өөс “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн хэвлэлийн эрх чөлөө” судалгааг 2020 оны 12 дугаар сард 300 сэтгүүлчийг хамруулан хийв. Уг судалгааны үр дүнгээр, нийт оролцогчдын 60 орчим хувь нь эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хангахад саад бэрхшээл учирсан гэж үзжээ. Төрийн байгууллагын зүгээс ямар нэгэн дарамт, шахалтад өртсөн тухайгаа судалгаанд оролцогчдын 75% зөвшөөрсөн бол бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнээс хойш хэвлэлийн эрх чөлөө хумигдсан гэдэгтэй судалгаанд оролцогчдын 59% нь санал нийлж буйгаа илэрхийлсэн байна.²⁵

²⁵ <http://www.mediacouncil.mn/a/242>

ХЭҮК-ын дэргэдэх Ажлын хэсгээс 81 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын дунд хийсэн судалгаанаас харахад, дийлэнх оролцогчид Монгол дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний нөхцөл байдлыг “дунд” түвшинд байгаа гэж үнэлсэн байна. Үүнд, хэвлэл мэдээллийн эрх чөлөө ба сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэн явуулахад хэд хэдэн саад бэрхшээл тулгарч байгааг онцолжээ. Судалгаанд оролцогсдын 95 хувь нь мэдээлэл олж авахад бэрхшээлтэй тулгардаг гэж хариулсан бөгөөд үүнд төрийн төсөв, санхүүтэй холбоотой мэдээлэл авахад хамгийн их хүндрэлтэй гэж 61.7 хувь үзсэн бол төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн талаар гэж 48.1 хувь нь хариулжээ. Төрийн албаны хүнд суртал хамгийн ихээр саад тотгор болдог бол төрийн албаны хаалттай байдал, тодорхойгүй байдал, нууцын зэрэглэл, хаалтын гэрээ зэрэг асуудал хүндрэл учруулдаг гэжээ. Нөгөөтээгүүр, мэдээлэл өгөхөөс татгалзсан, эсвэл үл тоосон байгууллагуудын зүгээс “дарга зөвшөөрөөгүй” (53.7%), “хувь, төрийн, байгууллагын хувь хүний нууц” (43.9%), “энэ мэдээллийг өгөх эрх мэдэл байхгүй” (40.2%) гэх мэтээр хариулт өгдөг гэжээ. Мэдээлэл авах, түгээх зэрэг сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад нь судалгаанд оролцогчдын 85% нь ямар нэг байдлаар бэрхшээлтэй тулгардаг гэсэн бөгөөд давтамжийн хувьд өдөр тутам 14.8%, хааяа 58%, ховор 13.6%-д тохиолддог гэж хариулсан байна. Мөн мэдээллийн эх сурвалжаа ил болгохыг эрх бүхий байгууллагаас шаарддаг тохиолдол судалгаанд оролцогсдын 81.5%-д нь тохиожээ.

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын бие даасан, хараат бус, аюулгүй байдлын талаарх асуудлыг хөндөхөд, дарамт шахалт ирдэг эсэх талаар 80 хүн хариулснаас зөвхөн 8.8% үгүй гэж хариулжээ. Хэвлэл мэдээллийн байгууллагын редакц, үүсгэн байгуулагч, эзэмшигч, хөрөнгө оруулагчдын талаас сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд оролцдоггүй гэж зөвхөн 3.7 хувь нь хариулсан байна. Эцэст нь, судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар, хэвлэл мэдээллийн салбарт эрэн сурвалжлагч (69.5%), улс төрийн (28%), мэдээний (13.4%) чиглэлээр ажилладаг сэтгүүлчид эрсдэлд өртөх өндөр магадлалтай байна.

Өнгөрсөн жилийн бас нэг онцлох асуудал бол МҮОНРТ-ийн уран бүтээлчид болон тус байгууллагын Үндэсний зөвлөл, Захирлуудын зөвлөлийн хооронд үүссэн маргаан байв. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд МҮОНРТ-ийг “гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд мөн” хэмээн заасан. Гэтэл олон нийтийн гэх тодотголтой МҮОНРТ-ийн удирдлагын томилгоо олон нийтийн оролцоонд тулгуурладаггүй, улс төрийн нөлөөлөл дор явагдаж ирснийг нийтээр хүлээн зөвшөөрдөг. МҮОНРТ-ийн хамт олны зөвлөл, үйлдвэрчний эвлэлийн зүгээс 2020 оны 9 дүгээр сараас эхлэн тус байгууллагад үүссэн нөхцөл байдалтай холбоотой эсэргүүцлээ илэрхийлж, тус байгууллагын Ерөнхий захирал, Үндэсний зөвлөлийн гишүүдийг сонгохтой холбоотой асуудлаар

байр сууриа илэрхийлэн, тэмцэл өрнүүлсэн. Ингэхдээ, ажиллагсдын хөдөлмөрлөх эрхийг ноцтой зөрчсөн, уран бүтээлчдийг тагнаж чагнасан, редакцын хараат бус байдлыг алдагдуулсан, төсвийн хөрөнгийг зүй бусаар зарцуулсан, улс төрийн нөлөөлөлд автагдсан зэргээр хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж чадаагүй тул удирдах дээд байгууллага болох Үндэсний зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрохыг МҮОНРТ-ийн 500 гаруй сэтгүүлч, уран бүтээлчдийг төлөөлөн хамт олны зөвлөлөөс шаардсан бөгөөд эрх бүхий байгууллагуудад удаа дараа захидал, шаардлага, албан бичиг явуулах, хуран цуглах зэрэг хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлж байсан.

ХЭҮК-оос хөдөлмөрлөх эрх, мэргэжлийн эрх зөрчигдөж байгаа талаарх гомдлын мөрөөр хяналт, шалгалт хийж, холбогдох талуудад шаардлага, зөвлөмж хүргүүлсэн. Мөн ГИТ тэргүүтэй Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын Форумын зүгээс МҮОНРТ-д үүссэн нөхцөл байдалтай холбоотой байр сууриа удаа дараа илэрхийлж, тус байгууллагын Үндэсний зөвлөл, УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, Ерөнхий сайд, Ерөнхийлөгч, УИХ-ын даргад МҮОНРТ-ийн хараат бус байдлыг хангах талаар шаардлага, зөвлөмж хүргүүлсэн. Үүнд, 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдөр УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороогоор бүрэн эрх дуусгавар болсон гишүүний орон тоон дээр нэр дэвшсэн хүмүүсийг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах үйл явц нэр төдий явагдаж, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т заасан “...иргэний нийгмийн төлөөллөөс санал болгосон иргэнийг томилно” гэсэн заалтыг үл хайхарсан, нэр дэвшсэн хүмүүсийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан нийтлэг зарчмыг үл баримтлан, үг хэлэх, тайлбар санал хэлэх боломжгүй, олон нийтэд тухайн хүмүүсийг бүрэн танилцуулалгүй, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хатуу хөл хорио тогтоосон үед яаравчлан хэлэлцсэн нь хараат бус, олон ургальч, ил тод ажиллах зарчим бүхий МҮОНРТ-ийн удирдах дээд байгууллагын томилгоонд хайнга хандсан, хариуцлагагүй үйл явдал болсон гэж Хүний эрхийн Форум үзэж, эсэргүүцлээ илэрхийлсэн. Хамт олны эсэргүүцэл гараад багагүй хугацаа өнгөрч байхад асуудлыг үл хайхарсан дээрх шийдвэр нь тэмцлийн хэлбэрийг хурцатгаж жагсаал, цуглаан хийх, хүч хэрэглэхээр сүрдүүлсэн нөхцөл байдал үүсгэсэн.

МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн гишүүдийг томилохдоо иргэний нийгмийн төлөөллөөс санал болгосны дагуу ил тод, нээлттэй хэлэлцэж, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу томилгооны сонсгол зохион байгуулах замаар томилох шаардлагатай. Салбарын хуулийн зохицуулалт хангалтгүй байгаагаас үүдэн Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийг Хууль тогтоомжийн тухай хуулийг баримтлан, иргэдийн оролцоог хангах замаар шинэчлэн найруулж, батлах нэн шаардлагатай байна.

Глоб Интернэшнл төв үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний дараах зөрчлийг онцолж байна.

Глоб Интернэшнл төв 2020-2021 оны хооронд нийт 31 иргэн, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтанд хууль, эрх зүйн үнэгүй зөвлөгөө өгсөн. Үүнд, орон нутгийн 4, Улаанбаатар хотын 27 хүн байна. Эрх зүйн зөвлөгөөг төрлөөр нь авч үзвэл цар тахлын үед мэдээ, мэдээлэл бэлтгэсэнтэй холбоотойгоор Зөрчлийн болон Эрүүгийн хуулиар цагдаагийн байгууллагад шалгагдах зөрчил дийлэнх хувийг эзэлж байна.

Зөрчил 1. Сэтгүүлчийг хууль бусаар жагсаал цуглаан зохион байгуулсан гэх үндэслэлээр торгох шийтгэл оногдуулав.

МҮОНРТ-ийн сэтгүүлч П болон тус телевизийн Түр зөвлөлийн гишүүдээс 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Олон нийтийн радио телевизийн Ерөнхий захирал, Үндэсний зөвлөлийн гишүүдийн томилгоог эсэргүүцэж, тайван замаар үзэл бодлоо илэрхийлсэн. Гэвч Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтсээс нэр бүхий хүмүүсийг хүчээр авч явж, албадан саатуулсан. Улмаар 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Зөрчлийн тухай хуулийн 5.8.1 дэх хэсэг Жагсаал, цуглаан зохион байгуулах журам зөрчсөн гэх үндэслэлээр 100,000 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн. Гэвч тус заалтаар иргэнийг 150,000 төгрөгөөр торгох шийтгэлтэй байдаг. Энэ хэрэг дээр эрх бүхий байгууллагаас жагсаал, цуглааныг албадан тараахдаа хуульд заасан үндэслэл болох мэдэгдэл танилцуулснаас хойш 2 цагийн дотор тараагүй бол албадан тараана гэсэн заалтыг баримтлаагүй. Цар тахлын болон Гамшгаас хамгаалах тухай хуульд бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын үед иргэний үндсэн эрхийг хамгаалахтай холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулаагүйн улмаас зарим эрх зөрчигдөхөд хүрч байна.

Зөрчил 2. Сэтгүүлчийг нэр төр, алдар хүндэд халдсан хэмээн Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргав.

Зариг.mn сайтын сэтгүүлч Ө нь Монгол банкны эрсдэлийн сангаас “Монполимет” ХХК 10 тэрбум төгрөгийн өрөө хаалгуулсан асуудлаар мэдээ бэлтгэсэн. Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээс УИХ-ын гишүүн асан Г-ын нэхэмжлэлтэй холбогдох хэрэгт 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдөр иргэний хэрэг үүсгэсэн. Нэхэмжлэгчээс 2019-2020 онуудад Зариг.mn сайтаар болон сэтгүүлчийн хувийн цахим хуудастаа бичсэн нийт 138 мэдээ, постод холбогдуулан нэхэмжлэлийн шаардлага гаргасан. Иргэний хуулийн 21 дүгээр зүйл нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаахтай холбоотойгоор нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болгож 100 гаруй мэдээ, постонд холбогдуулан нэхэмжлэл гаргаж байсан тохиолдол өмнө бүртгэгдэж байгаагүй. Шүүхийн шийдвэр одоог хүртэл эцэслэн гараагүй бөгөөд шүүх хурал 9 дэх удаагаа хойшлоод байна.

Зөрчил 3. Үзэл бодлоо илэрхийлж, “шүгэл” үлээсний төлөө Зөрчлийн хуулиар торгож, Эрүүгийн хуулиар яллагдагчаар татав.

Иргэн М нь Энхсаран сувилалд тусгаарлагдаж байхдаа коронавирусийн халдвар авсан болох нь түүний 4 дэх шинжилгээгээр тогтоогдсон. Тухайн иргэн 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр өөрийн цахим хуудсаараа дамжуулан тус сувилалд халдвар хамгааллын дэглэм муу, ариун цэвэр хангалтгүй, хулганаар дамжин халдвар тархах эрсдэлтэй байгааг олон нийтэд анхааруулсан өдрийн маргааш Засгийн газрын 178 дугаар тогтоолоор бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн. 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн ЦЕГ-ын НХЖОНАБА-ны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн эрх бүхий албан тушаалтан М-д Зөрчлийн тухай хуулийн 5.13.1 дэх заалтаар торгох шийтгэл оногдуулсан. Шийтгэлийн хуудсыг эс зөвшөөрч Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасан боловч одоогоор шүүх хурлын тов гараагүй байна.

Мөн 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдөр Хан-Уул дүүргийн Прокурорын газраас иргэн М-г Эрүүгийн хуулийн 15.6.1 дэх хэсэг болох “Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин бусдад халдаах, эсхүл тархах нөхцөл бүрдүүлэх” зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан. ГИТ-өөс эдгээр хэргүүдэд өмгөөллийн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлж байна.

Зөрчил 4. Цар тахлын үеэр төрийн байгууллага нь үнэн бодит мэдээлэл түгээгээгүй

Увс аймгийн ЗДТ-ын газраас цахим хуудастаа цар тахлын асуудлаар мэдээ нийтэлсэн бөгөөд 30 минутын дараа тухайн мэдээгээ устгасан байна. Уг мэдээллийг хуваалцсан аймгийн сэтгүүлч Э-г утсаар дарамтлан, мэдээгээ устгахыг шаардсан. Энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 13.14 “худал мэдээлэл тараах” гэмт хэрэгт хуулийн этгээд хариуцлага хүлээж болно. Мөн Зөрчлийн хуулийн 5.13.1 дэх хэсэгт “олон нийтийг төөрөгдүүлэх” худал мэдээ, мэдээлэл түгээсэн хуулийн этгээд 5 сая төгрөгийн торгуультай. ГИТ-өөс цагдаагийн байгууллагад гаргах гомдлын төслийг бичиж өгсөн. Цар тахлын үед төвийн болон орон нутгийн сэтгүүлчдийн аль алинд ийм асуудал түгээмэл тохиолдож байна. Гэвч цар тахлын тухай хуулийн 7.1.11-д цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах нь Засгийн газрын үүрэг байхаар хуульчилсан.

Зөрчил 5. Сэтгүүлчийг нууц эх сурвалжаа илчлэхийг цагдаагийн байгууллагаас шаардав.

Архангай аймгийн сэтгүүлч А-ийн редакцад тус аймгийн цагдаагийн хэлтсээс “мэдээнийтэлсэн албанхаагчдын талаарх мэдээлэл шаардлагатай байх тул яаралтай ирүүлж хамтран ажиллана уу” гэсэн утга бүхий албан тоот ирсэн. Мөн Зариг.мн сайтад эх сурвалжаа илчлэхийг хүссэн албан тоот ЦЕГ-ын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах албанаас 2020.09.17 өдөр ирүүлсэн. Эндээс үзвэл, эх сурвалжаа илчлэхийг албадах үзэгдэл нийтлэг хэвээр байгаа бөгөөд эрх бүхий байгууллагаас албадахаас илүүтэйгээр хамтран ажиллах нэрийдлээр шаардах нь ихэссэн байна. Гэвч Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчийн төрлөөр ангилан сэтгүүлчдийг ялгаварлаж, зөвхөн олон нийтийн радио, телевизийн ажилтанд хамаарах заалт гэж ойлгох нь учир дутагдалтай бөгөөд жишгийн эрх зүйгээр бүх сэтгүүлчдэд олгогдсон эрх юм. Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 8-д “Мэдээллийн эх сурвалжаа чандлан хамгаална” гэж заасан нь сэтгүүлчийн заавал мөрдөх ёс зүйн үүрэг тул эх сурвалж албадахыг хэрхэвч зөвшөөрөх ёсгүй.

Зөрчил 6. Орон нутгийн сэтгүүлчдийн мэдээлэл авах, түгээх эрхэд халдав.

Орхон аймагт сэтгүүлчдийн үнэн бодит мэдээллийг баталгаатай эх сурвалжаас авч олон нийтэд түгээх мэргэжлийн эрх ноцтойгоор зөрчигдсөн тохиолдол гарсан. Тус аймгийн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагууд өдөр тутамдаа мэргэжлийн үүргээ гүйцэтгэхэд хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. Тухайлбал, аймгийн ЗДТГ-ын зүгээс хурал, уулзалтын талаарх холбогдох мэдээллийг өгөхөөс татгалзах, сэтгүүлчдийн мэдээлэл хайх, олж авах, түгээх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлах, орон нутаг дахь хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчдийн үйл ажиллагаанд саад учруулах, зөвхөн гэрээ байгуулсан тохиолдолд сэтгүүлчдэд мэдээлэл өгөх, гэрээ байгуулаагүй нөхцөлд мэдээлэл өгөхөөс татгалзах зэргээр сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсээр байна. Мөн эрх бүхий албан тушаалтнууд гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаан дахь санхүүгийн мэдээлэл, шилэн дансны мэдээллийг нууцлах зэрэг зөрчил гарчээ. ГИТ-өөс аймгийн Засаг даргад хандаж, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.1-т заасны дагуу нийтэд мэдээлэхийг хориглоогүй мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх үүргээ хэрэгжүүлэх, мөн сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, саад хийхгүй байхыг шаардсан захидал илгээсэн.

ГУРАВ

СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
ЭСРЭГ ИРГЭНИЙ БА ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

2020 онд иргэний хэргийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эдийн бус гэм хорын хохирол учруулсантай холбоотойгоор шүүхээс шийдвэрлэгдсэн 106 хэрэг байна. Энэ нь 1999 оноос манай байгууллагын бүртгэснээс хойших хугацаанд гарсан хамгийн өндөр үзүүлэлт юм. Эрүүгийн хуульд 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулснаар 13.14-т “худал мэдээлэл тараах”-ыг гэмт хэрэгт тооцох болсон. 2020 онд худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотой 17 хэрэг шүүхээс эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Үүний тал орчим хувьд буюу 8 хэрэгт нь улс төрийн өндөр албан тушаалтан, УИХ-ын гишүүн, төрийн албан хаагч, төрийн байгууллагаас гаргасан өргөдөл, гомдолд үндэслэж шүүхээс ял оногдуулжээ.

Хүснэгт 1. 1999-2020 оны хэргийн харьцуулсан үзүүлэлт

Он	Иргэний хэрэг		Эрүүгийн хэрэг	
	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах
1999	30	-	3	-
2000	39	-	-	-
2001	31	11	4	-
2002	44	37	2	2
2003	28	18	1	1
2004	40	40	1	1
2005	29	25	1	1
2006	36	31	3	3
2007	33	33	-	-
2008	39	25	5	5
2009	44	17	1	-
2010	67	37	2	-
2011	43	23	7	3
2012	43	20	8	4

2013	37	17	9	3
2014	45	20	12	9
2015	37	10	14	5
2016	47	12	9	1
2017	49	12	5	0
2018	69	19	0	0
2019	36	11	1	0
2020	106	14*	17	1
Нийт	972	432	105	39

* Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн албан тоотод нийт шийдэгдсэн 106 хэрэг маргаанаас хэд нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой талаарх дэлгэрэнгүй статистик мэдээлэл хөтөлдөггүй талаар дурдсан.

Нээлттэй цахим сан болох Shuukh.mn сайтаас эдийн бус гэм хорыг арилгах, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасантай холбоотой анхан шатны 24, давж заалдах шатны 18, хяналтын шатны 5, нийт 47 шүүхийн шийдвэрийг байршуулсан байгаагаас сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагатай холбоотой шийдвэрлэсэн хэргийн тоо 14 буюу 30 орчим хувь байна.

Худал мэдээлэл тараах гэмт хэрэгтэй холбоотойгоор 17 хэргээс нэг нь сэтгүүлчид торгох ял оноож шийдвэрлэсэн бол хэвлэл мэдээллийн хэрэгслийг дангаар нь шийтгэсэн тохиолдол байхгүй. Эрүүгийн хэргийн хувьд шүүхээс оногдуулсан мөнгөн торгуулийн дээд хэмжээ нь 1.3 сая төгрөг байв. Мөн энэхүү хэрэгт шалгагдаж байх хугацаандаа таслан сэргийлэх арга хэмжээ авч, 53 хоногийн хугацаанд цагдан хоригдсон тохиолдол гарсан бөгөөд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасны дагуу цагдан хоригдсон нийт хугацааг торгох ялын дүнгээс хасаж, 505.000 төгрөгийн торгох ял оногдуулсан байна. Худал мэдээлэл тараах гэмт хэргийн хувьд, шүүхээс шийдвэрлэгдсэн хэрэгт нэхэмжлэл гаргагчдын 37,5% нь төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага байна.

2020 онд нэхэмжлэгч талаас сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад гаргаж буй эдийн бус гэм хорыг арилгах хохиролд дунджаар 4.3 сая төгрөг нэхэмжилсэн байна. Эдийн бус гэм хорыг арилгах хохиролд олны танил улс төрчийн эзэмшдэг компаниас хэвлэл мэдээллийн хэрэгслээс нэг тэрбум

төгрөг нэхэмжилсэн боловч одоог хүртэл анхан шатны шүүх хуралдаан товлөгдоогүй байна.

1990-2020 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд болон гүтгэлэг, доромжлол, илт худал мэдээлэл тараахтай холбоотой шүүхээс шийдвэрлэгдсэн нийт **1077** иргэний болон эрүүгийн хэргийн **43.7%** сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох хэрэг байна.

Тайлбар. 2017, 2018 онд ХМХ-д хамаарах эрүүгийн хэргийн бүртгэл байхгүй байгаа нь Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 7 дугаар сарын нэгний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр “гүтгэх, доромжлох” зүйл ангийг гэмт хэрэгт тооцохгүй болсонтой холбоотой.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэх талаар НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлөөс Монгол улсад өгсөн зөвлөмж (UPR)

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг буюу Universal Periodic Review (UPR) бол НҮБ-ын онцгой механизм юм. Уг механизмын дагуу НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 4.5 жил тутам гишүүн 193 улс бүрийн хүний эрхийн төлөв байдал, тэдний нэгдэн орсон олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэн хэлэлцэх зорилгоор “Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг” явуулдаг.

Үүний дагуу Монгол Улс НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн Ажлын хэсгийн чуулганаар Хүний эрхийн төлөв байдлын үндэсний илтгэлээ анх удаа 2010 онд, 2 дугаар илтгэлээ 2015 онд, харин 2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр гуравдугаар илтгэлээ хэлэлцүүлсэн юм.

Глоб Интернэшнл төвөөс 2015 болон 2020 онд явагдсан хэлэлцүүлэгт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хэрэгжилтийн талаарх тайланг олон талын оролцоотойгоор бэлтгэж, Монголын Хүний эрхийн ТББ-уудын Форумын тайлангийн нэг хэсэг болгон тус тус илгээсэн юм. 2015 онд НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлөөс Монгол улсын Засгийн газарт үзэл бодолтой байх эрх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөг бүрэн дүүрэн хангахтай холбоотойгоор дараах зөвлөмжүүдийг өгч байв. Үүнд:

- үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбогдох үндэсний хууль тогтоомжийг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэх,
- өргөн нэвтрүүлгийн зохицуулах байгууллагын хараат бус байдлыг хангах,
- Эрүүгийн хуулийн нэр төр гутаахтай холбоотой зүйл заалтыг халах, тэдгээр зүйл заалтыг шүүмжлэлийг таслан зогсоох зорилгоор ашиглахгүй байх, нэр төр гутаахтай холбоотой хэргийг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн иргэний журмаар шийдвэрлэх,
- сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалж болон шүгэлдэгчдийг хамгаалах нөхцөл бүрдүүлэх,
- интернэтийг хамруулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах,
- үзэл бодлоо илэрхийлэх эрхийг аливаа байдлаар хязгаарлахдаа “хууль ёсны байх”, “зайлшгүй байх”, “хэм хэмжээндээ байх” зарчмыг дээдлэх,

- сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангах,
- эрхбүхий байгууллагын үйл ажиллагааг сурвалжилсан, шүүмжилсний улмаас мөрдөн хавчигдах, дарамт шахалтаас хамгаалах нөхцөл бүрдүүлэх зэрэг зөвлөмжийг өгч байв.

Харамсалтай нь дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас дорвитой алхам хийсэнгүй гурав дахь хэлэлцүүлэгтэй золгосон юм.

2020 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн 36 дахь чуулганаар Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлыг гурав дахь удаагаа дүгнэн хэлэлцэв. Тус чуулганыг 2020 оны 5 дугаар сарын 4-15-ны өдөр товлосон байсан хэдий ч дэлхийн нийтийг хамарсан КОВИД-19 цар тахлын улмаас ийнхүү хойшилж, цахимаар явагдсан юм. Тус чуулганаар Хүний эрхийн зөвлөлөөс Монгол улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бүрэн утгаар нь хэрэгжүүлэх талаар дараах зөвлөмжийг өгсөн юм. Үүнд:

- Гүтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх арга хэмжээ авах зэрэг замаар сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан болон иргэний нийгмийн идэвхтнүүд аливаа шийтгэл хүлээнэ гэх айдасгүйгээр үйл ажиллагаагаа олон улсын хэм хэмжээний дагуу чөлөөтэй явуулах нөхцөлийг хангах - 69 (Эстони);
- Зөрчлийн тухай хуулийн 6.21 дэх заалтыг хүчингүй болгох замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах - 70 (ИБУИНХУ);
- Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг үйлдсэн халдлагын хэргийг хараат бусаар мөрдөн шалгах нөхцөлийг баталгаажуулж, гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд шийтгэл хүлээлгэх – 71 (Австрали);
- Хүний эрх хамгаалагчид, иргэний нийгмийн байгууллагуудыг заналхийлэх, айлган сүрдүүлэх, дарамтлахаас хамгаалсан хууль тогтоомж батлан хэрэгжүүлэх, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг үйлдсэн халдлагын хэргийг мөрдөн шалгах, буруутай этгээдэд хариуцлага оногдуулах - 72 (Чех);
- Хувь хүний нууцаа хамгаалуулах эрхийг хөхиүлэн дэмжиж, улам сайн хамгаалах зорилгоор өгөгдөл хамгаалах үр дүнтэй хууль тогтоомж батлах, ингэхдээ хуульд нийцсэн байх, зайлшгүй байх болон хязгаарлалтын хүрээ нь хэм хэмжээнд нийцсэн байх зарчмыг баримтлах - 78 (ХБНГУ);
- Шүүхийн шударга, ил тод байдлыг хангах, эрүүдэн шүүхэд оролцсон этгээдэд хариуцлага оногдуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон интернэтийн хэрэглээнд тогтоосон хязгаарлалтыг цуцлах талаар шаардлагатай хүчин чармайлт гаргах – 88 (Египет).

КОВИД-19 цар тахлын үе дэх иргэний болон улс төрийн эрхийн зөрчлийн мониторинг (Глоб Интернэшнл төв)

/2020.11.20 - 2021.02.25/

Мониторингийн зорилго: КОВИД-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ нь олон улсын хүний эрхийн хязгаарлалтын зарчимд нийцэж буй эсэхийг үнэлэх, цар тахлын үед мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журмыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэхэд нөлөөлөхөд оршино.

Мониторингийн үйл ажиллагаа: КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ болох өндөржүүлсэн бэлэн байдлын үе, бүх нийтийн бэлэн байдлын хугацаанд гарсан иргэний болон улс төрийн эрхийн зөрчлийн мониторингийг 3 сарын хугацаанд хийж гүйцэтгэв.

Зөрчлийн бүртгэл

Хамгийн их хандалттай, тогтмол ажиллагаатай 20 цахим хуудас болон фэйсбүүк, твиттерийн орчинд шүүлт хийх, хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлагад хандаж, аливаа зөрчил гарсан эсэх, зөрчил гарсан тохиолдолд мэдээлэх тухай захидал илгээх, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчидтэй утсаар холбогдон зөрчил бүртгэх, төрийн байгууллагаас мэдээлэл хүсэх /ХЭҮК, УЕПГ/, Google Forms ашиглан цахимаар бичил судалгаа хийх замаар мэдээлэл цуглуулав. Мониторингийн хугацаанд давхардсан тоогоор иргэний болон улс төрийн эрхийн нийт 79 зөрчил бүртгэв.



Үүнээс, цахим хуудас, нийгмийн сүлжээнээс нийт 43 зөрчил, Google Form-оор 24 зөрчил, ХЭҮК-т бүртгүүлсэн 4 зөрчил, хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчидтэй утсаар холбогдон бүртгэсэн 8 зөрчил байв. Эдгээр зөрчлийн 48% нь мэдээлэл олж авах, түгээх, боловсруулахтай холбоотой эрх, 30% нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчил байв. Харин 17% нь эвлэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхийн зөрчил, үлдсэн 5% нь шашин шүтэх, эс шүтэх эрхийг зөрчсөн тохиолдол байв.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан зөрчлийн мэдээллийг агуулгаар нь багцалбал:

- Олны танил залуус өөрийн нийгмийн сүлжээний хуудсаар үзэл бодлоо илэрхийлсэн пост нийтэлснийг хориглосон тохиолдлууд.
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын гомдлоор үүссэн нэр бүхий иргэний болон сэтгүүлчийн эсрэг үүсгэсэн эрүүгийн хэргүүд.
- Цахим орчинд өөрийн фэйсбүүк хуудсаар дамжуулан үзэл бодлоо илэрхийлсэн иргэдийг торгосон, сүрдүүлсэн тохиолдлууд.
- ХХЗХ-оос цахим хуудсуудад ... коронавирусийн халдвар, тархалтын талаарх мэдээ мэдээллийг хэрэглэгчийн сэтгэгдэл авах боломжгүй тохиргоотойгоор нийтлэх, ...хувь хүний мэдээллийг өөрийн веб сайтад нийтлэхгүй байх, нийтэлсэн тохиолдолд Монгол улсаас хандах хандалтыг хязгаарлах хүртэл арга хэмжээ авах талаарх мэдэгдэл.
- Тусгаарлалтад байсан иргэд групп чат үүсгэн харилцахыг хориглосон тохиолдол.

Мэдэх олж авах, түгээх, боловсруулахтай холбоотой эрхийг хязгаарласан зөрчлийн мэдээллийг агуулгаар нь багцалбал:

- Иргэд эмнэлгийн тусламж авах зорилгоор төрийн байгууллагын 103, 119 зэрэг дугааруудад холбогдоход тодорхой хариу өгөхгүй, бие бие рүүгээ дамжуулах, утсаа авахгүй байх зэрэг тохиолдол ихээр гарав. Үүнээс үүдэн яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадахгүй хохирох, коронавирусээс бусад эрүүл мэндийн асуудлаар тусламж үйлчилгээ авахад хүндрэл үүссэн.
- Хэвлэл мэдээллийн байгууллагуудаас заавал автомашины QR код авч зорчихыг шаардах, QR код авахад нь үндэслэл, тайлбаргүйгээр квот тогтоосон явдал.
- Эрүүл мэндийн яамнаас мэдээлэл авах эрхтэй сэтгүүлчдийн тоог хязгаарласан тохиолдол.

- Төрийн байгууллагаас өгч буй мэдээлэл иргэдэд ойлгомжтой бус, байгууллага хоорондын уялдаа холбоогүйн улмаас иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирч буй тохиолдлууд.
- PCR шинжилгээ хийлгээгүй иргэдэд төрийн байгууллага үйлчилгээ үзүүлэхгүй байх тухай мэдэгдэл.
- Зөвхөн албаны эх сурвалжаас мэдээлсэн, бэлтгэсэн мэдээлэл түгээхийг шаардах явдал.
- Нэг сувгаар мэдээлэл түгээхээр зохицуулсан Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 29 дүгээр тогтоол.
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд мэргэжлийн үүргээ гүйцэтгэхэд нь дарамт, шахалт үзүүлэх явдал түгээмэл болсон.

Эвлэлдэн нэгдэх эрх, тайван замаар жагсаал цуглаан зохион байгуулах эрхийг хязгаарласан зөрчлийг агуулгаар нь багцалбал:

- Иргэд сайн дураараа эвлэлдэн нэгдэж, тайван замаар жагсаал, цуглаан зохион байгуулсан тохиолдолд хязгаарлалт тогтоосон зөрчил.
- МҮОНРТ-ийн Хамт олны зөвлөлөөс зохион байгуулсан тус телевизийн Ерөнхий захирлын томилгоотой холбоотой Үндэсний зөвлөлийн шийдвэрийг эсэргүүцсэн жагсаал цуглааныг тодорхой үндэслэл, хуулийн тайлбаргүйгээр хязгаарлаж, сэтгүүлчийг албадан авч явж, мэдүүлэг авсан хэрэг.
- Мониторингийн хугацаанд 20 цахим хуудасны 2020 оны 1 дүгээр сарын 27-ноос 2021 оны 2 дугаар сарын 25-ныг хүртэлх мэдээллийг шүүх замаар зөрчлийн бүртгэл хийв. Мониторинг хийх цахим хуудсыг сонгохдоо цахим хуудасны хэрэглэгчдийн хандалтын рейтинг тогтоодог www.alexa.com/topsites/countries/MN хуудсын судалгааг ашиглан хамгийн олон хандалттай, мэдээний 13 цахим хуудас, хандалт нь өсөж буй 7 цахим хуудсыг сонгон хийв.
- Орон нутгийн болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагын 50 гаруй сэтгүүлчтэй утсаар холбогдож, ажил үүргээ гүйцэтгэхэд нь аливаа зөрчил, саад бэрхшээл гарч байгаа талаар тодруулав. Нийслэлийн ихэнх сэтгүүлч хэвийн гэж мэдэгдсэн бол орон нутгийн сэтгүүлчдэд хүндрэл бэрхшээл нэлээдгүй тулгарч байгаа гэв. Тухайлбал, Говь-Алтай, Орхон, Ховд, Увс, Төв зэрэг аймгийн сэтгүүлчдийн мэдээлэл олж авах, боловсруулах, түгээх явцад хүндрэл тулгарч байна. Тухайн орон нутгийн ЗДТГ нь нийтэлсэн мэдээлэлд цензур тавих, устгахыг шаардах, торгох зэрэг

арга хэмжээ авч байна. Түүнчлэн зарим тохиолдолд мэдээллийг төрийн байгууллага мэдээлэхээс өмнө олон нийтэд түгээхийг хориглосон тохиолдол гарсан.

- Google Forms ашиглаж хийсэн зөрчил бүртгэх бичил судалгаа: <https://docs.google.com> ашиглан зөрчил мэдээлэх судалгаа явуулав. Судалгааг орон нутгийн болон Улаанбаатар хотын 100 орчим сэтгүүлчийн имэйл хаягаар судалгааны маягтад нэвтрэх линк илгээх болон, фэйсбүүк хуудсанд нээлттэй байршуулах замаар хийв. 2021 оны 2 дугаар сарын 25-ны байдлаар 24 хүн судалгаа бөглөж ирүүлснээс сэтгүүлч 19, жирийн иргэн 3, иргэний нийгмийн төлөөлөл 1 хүн байв. Нийт 17 хүн зөрчилтэй гэж хариулсан бол үлдсэн 7 хүн нь ямар нэгэн зөрчил гараагүй гэж хариулсан юм. Судалгаанд оролцогчдын 46% нь орон нутгийн төлөөлөл, 54% нь Улаанбаатар хотын төлөөлөл байв. Үүнээс давхардсан тоогоор үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зөрчигдсөн тохиолдол 8, мэдэх эрх, мэдээлэл авах, түгээх эрхтэй холбоотой зөрчил гарсан хэмээн 16 хүн хариулжээ. Тус судалгаагаар бүртгэгдсэн зөрчлийн 25 хувийг төрийн албан тушаалтан үйлдсэн гэсэн бол 21 хувийг УОК-ын эрх бүхий албан тушаалтан, 12 хувийг Аймгийн онцгой комисс, 8 хувийг цагдаагийн ажилтан үйлдсэн гэж хариулжээ.

ГИТ-ийн хариу арга хэмжээ:

1. Монгол улсын Засгийн газар, УОК-т хандаж уриалга гаргав.
2. IFEX, Forum Asia, GFMD зэрэг олон улсын байгууллагуудад Монгол Улсын Засгийн газар болон УОК-т хандан уриалга гаргасан талаараа хэвлэлийн мэдээ бэлтгэн хүргүүлэв.
3. УЕПГ-ын цахим хуудаст 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр гарсан мэдээлэлд Гамшгийн өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлснээс хойш хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн зөрчил гурав дахин өссөн тухай дурдсаны дагуу эдгээр зөрчлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл хүсэхэд тус газраас 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдөр хариу ирүүлэв.
4. 2020 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ГИТ нь ХЭФ-ын бусад гишүүдтэй хамтран МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлд хандан тус телевизийн Ерөнхий захирлын томилгоог улс төрийн нөлөөллөөс ангид явуулахыг шаардсан албан бичиг хүргүүлэв.
5. 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр ГИТ нь ХЭФ-ын бусад гишүүдтэй

хамтран МҮОНРТ-ийн уран бүтээлчдийн эхлүүлсэн тус телевизийн удирдлагуудтай холбогдох асуудлаар Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын гишүүдэд хандаж, шаардлага хүргүүлэв.

6. 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр хэвлэл мэдээллийн 32 байгууллагад мэдээлэл хүссэн албан бичиг хүргүүлэв. Тус бичгээр хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг ажил үүргээ гүйцэтгэхэд нь аливаа хэлбэрийн дарамт, шахалт сүрдүүлэг, цагдан хяналт гарч байгаа эсэх талаар мэдээлэл хүссэн юм. Түүнчлэн, бичиг хүргүүлсэн бүх байгууллага руу утсаар холбогдож, мэдээлэл цуглуулав.
7. 2021 оны 12 дугаар сарын 1-ний өдөр ХЭҮК-т зөрчлийн мэдээлэл солилцох тухай албан бичиг илгээв. Тус бичгийн хариу 2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр ирэв.
8. 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Орхон аймгийн Засаг даргад МИТБМАЭ-ийн тухай хуулийг биелүүлэх, тус аймгийн сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийг хүндэтгэхийг зөвлөсөн захидал хүргүүлэв.
9. 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр ХЭФ-ийн бусад гишүүдтэй хамтран ХЗДХ-ийн сайдад хандаж, иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдэх эрхийг хязгаарлахгүй байх, олон улсын хэм хэмжээ, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хуулиар олгогдсон эрхээ эдлэхэд нь саад учруулахгүй байх, олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалтаа биелүүлэн ажиллахыг уриалсан албан бичиг хүргүүлэв.

Дүгнэлт

КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ болох гамшгийн үеийн өндөржүүлсэн бэлэн байдлын болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд гарсан иргэний болон улс төрийн эрхийн зөрчлүүдэд хийсэн дүн шинжилгээгээр дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

- Зөрчлийг төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргаж байгаа нь ноцтой байна. Үүний шалтгаан нь тэдгээр албан тушаалтан цар тахлын үед аливаа шийдвэр, үйл ажиллагаа нь хүнийг эрхийг хамгийн багаар хязгаарлах, бодитой байх тухай хуульд заасан шаардлагыг бүрэн ойлгоогүй, судлаагүй байгаатай холбоотой гэж үзэж байна. Цар тахлын нөхцөл байдал цаашид ч үргэлжлэх

төлөвтэй байгаа тул төрийн албан тушаалтнууд бүх шатандаа Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр, дотоодын хууль тогтоомжоор баталгаажуулсан хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлсэн мэдлэг, ур чадвар, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа өрнүүлэх шаардлагатай байна.

- Түүнчлэн дээрх асуудлаарх ХЭҮК-оос УОК-т удаа дараа өгсөн зөвлөмж, шаардлагад албан ёсоор хариу өгсөн эсэх тодорхойгүй байгаа нь цар тахлын үед хүний эрхийг хангах механизмыг сайжруулах зайлшгүй шаардлагатайг илтгэж байна
- Цар тахлаар далимдуулан “хүн амын эрүүл мэндийг хамгаалах” гэдэг үндэслэлээр жагсаал, цуглааныг хориглох, хязгаарлах нь хүний үндсэн эрхийн зөрчил юм. Цаг үеийн тулгамдсан тодорхой асуудлаар иргэд байр сууриа илэрхийлэхэд хүн амын бөөгнөрөл үүсгэхгүй гэсэн үндэслэл тавьж хязгаарлахгүйгээр, халдвар хамгааллын дэглэмээ сахисан тохиолдолд тайван замаар хуран цуглах боломж олгох нь зүйтэй.
- Засгийн газраас өнгөрсөн хугацаанд үнэн бодит мэдээллийг тогтмол, шуурхай, цаг тухайд нь хүртээмжтэй байдлаар хүргэх үүргээ хангалттай биелүүлээгүйн улмаас иргэдийн суурь эрх, эрх чөлөө шууд зөрчигдөхөд хүргэж байна.
- Эрх бүхий байгууллагаас гарч буй аливаа тушаал, шийдвэр, захирамж нь хуульд үндэслэгдээгүй, захиргааны хэм хэмжээний актаар бүртгэгдээгүй боловч бүх нийтээр дагаж мөрдөхийг үүрэг болгож буй явдал хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөх эрсдэл дагуулж байна.

Глоб Интернэшнл төв

2021 он

